Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| | **Зорилт 1.1** Иргэдэд зориулсан спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.3/ | - | Ажлын явц, хувь | Спорт цогцолборын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. | 100% /Спортын цогцолборын зураг төсөл хийлгэнэ./ | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд "Спорт цогцолборын барилга"-ын зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр "Классик хаус" ХХК-тай гэрээ байгуулсан. Спорт цогцолборын барилга нь 586 үзэгчийн суудалтай. Сагсан бөмбөг, бокс, ресторан, фитнес, хурлын заал, ширээний теннис, ханын теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн танхимууд болон бусад дагалдах өрөө тасалгаануудтайгаар төлөвлөгдөн загвар зураг батлагдсан. Ажлын зураг боловсруулах явцад спорт цогцолборын эдэлбэр газрын давхцалтай холбоотой маргаан гарсанаас шалтгаалан зураг төсөв | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулах ажил 2022 оны 9 дүгээр сараас хойш зогсоод байна. | |
| 1 | Спортын цогцолборын барилгын зураг төсөл, төсвийг хийлгэн, барилга угсралтад шаардагдах хөрөнгийг улс, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлнэ. | 200.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан эсэх, ажлын явц, хувь | Спорт цогцолборын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. | 100% /Спортын цогцолборын зураг төсөл, төсвийг хийлгэж, төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна./ | Спортын цогцолборын барилга барих саналыг боловсруулан Монгол Улсын 2023 оны төсөвт тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дүгээр албан бичгээр, Нийслэлийн 2023 оны төсөвт тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06/295 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус уламжилсан. | 100% |
| **Зорилт 1.2** Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. /ЗГҮАХ 2.3.9.2/ | | - | Ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо, ажлын явц, хувь | ДТХО-аар хэрэгжих 2 цэцэрлэг гэрээ байгуулагдсан. | 100% /3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгана./ | Хан-Уул дүүргийн хэмжээнд 2022 онд 1, 3, 4, 5, 8, 9, 10, 12, 14, 15, 16, 18, 20, 21, 23, 24 дүгээр хороодод хэрэгжих нийт 4660 орны хүчин чадал бүхий 8 бага сургууль, цэцэрлэгийн барилга 18 цэцэрлэгийн барилгаас:<br>Улсын төсвийн хөрөнгөөр 1, 3, 4, 5, 8, 9, 13, 16, 20, 21, 23 дугаар хороодод 2840 ор бүхий 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 12 цэцэрлэгийн барилга;<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8, 9, 12, 14, 16, 23, 24 дүгээр хороодод 1220 ор бүхий 5 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 3 цэцэрлэгийн барилга;<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 15, 16, 24, дүгээр хороодод 600 ор бүхий 3 цэцэрлэгийн барилгын ажил тус тус хэрэгжиж байна.<br>Дээрх цэцэрлэгийн барилгуудаас 2022 онд 3, 4, 9, 13, 21, 23 дугаар хороондод нийт 1360 ор бүхий 1 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 5 цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон бол 5, 16 дугар хорооны 350 ор бүхий 2 цэцэрлэгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилгын ажлын явц 50-70 хувь, 1, 4, 20 дугаар хорооны, 440 ор бүхий 3 цэцэрлэгийн барилгын ажлын явц 30-49 хувь, 1, 10, 15 дугаар хорооны 3 цэцэрлэгийн барилгын ажлын явц 10-29 хувь, 8, 12, 14, 16, 18, 23,24 дүгээр хорооны 1420 ор бүхий 5 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 4 цэцэрлэгийн барилгын зураг төсвийн шатанд, 4, 8 дугаар хорооны 400 ор бүхий 2 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 1 цэцэрлэгийн барилга худалдан авах ажиллагааны шатанд байна.сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга-3, цэцэрлэгийн барилга-12 буюу нийт 15 төсөл арга хэмжээ, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бага сургууль, цэцэрлэгийн барилга-5, цэцэрлэгийн барилга-3 нийт 8 төсөл арга хэмжээ, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилга-3 буюу нийт 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дүүргийн хэмжээнд 2022 онд 180 суудал, 100 ортой 1 бага сургууль, цэцэрлэгийн барилга, 1260 орны багтаамжтай 5 цэцэрлэгийн барилга нийт 6 барилга ашиглалтад орлоо. | |
| 2 | Шинээр 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. | 5,944.0 /ДТХО/ | Ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо, ажлын явц, хувь | ДТХО-аар хэрэгжих 2 цэцэрлэг гэрээ байгуулагдсан. | 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажил дуусч, ашиглалтад орсон байна. | Дүүргийн хэмжээнд дараах цэцэрлэгийн барилгууд ашиглалтад орсон:<br>1. 13 дугаар хороонд баригдаж буй 180 суудал, 120 ор бүхий бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орсон /УТХО/ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. 3 дугаар хороо, 240 ортой 4-р цэцэрлэгийн барилга /УТХО/<br>5. 4-р хороо, 200 ортой цэцэрлэгийн барилга /ДТХО/<br>6. 9 дүгээр хороо 240 ортой 134-р цэцэрлэгийн барилга /УТХО/<br>7. 21 дүгээр хороо, 280 ортой цэцэрлэгийн барилга /УТХО/<br>8. 23 дугаар хороо, Хангарьд сити 2 хотхонд 300 ор бүхий Цэцэрлэгийн барилга /УТХО/ | |
| **Зорилт 1.3** Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.7.11/ | | - | Ашиглалтад орсон худгийн тоо | ДТХО-аар хэрэгжих 5 худгийн гэрээ байгуулагдсан. | 5-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Дүүргийн хэмжээнд шинээр 7 гүний худаг гаргаж, ашиглалтад оруулж, хуучин 6 худгийг смарт ажиллагаатай болгосон. | 100% |
| 3 | Гэр хорооллын шаардлагатай байршлуудад 5-аас доошгүй ундны усны худгийг ашиглалтад оруулна. | 240.0 /ДТХО/, 60.0 /ДОНХС | Ашиглалтад орсон худгийн тоо | ДТХО-аар хэрэгжих 5 худгийн гэрээ байгуулагдсан. | 5-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хөрөнгөөр он дамжиж хэрэгжсэн 12, 13 дугаар хороонд 2 гүний худаг, 2022 онд 9, 12, 13, 14 дүгээр хороонд шинээр 5 гүний худаг гаргаж, ашиглалтад оруулсан.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 11 дүгээр хороонд 1, 14 дүгээр хороонд хуучин 5 гүний худгийг ухаалаг систем суурилуулсан. | 100% |
| **Зорилт 1.4** Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно. /ЗГҮАХ 3.7.12/ | | - | Зураг төсөв хийлгэж, төсөвт санал уламжилсан эсэх, ажлын явц, хувь | Нисэхт 2 байршилд үерийн далан сувгийн зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулагдсан. | 2 байршилд зураг төсөв хийлгэж, төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна. | Нисэхийн бүсэд /9 , 10, 16 дугаар хороо/ үерийн ус зайлуулах шугам сүлжээний зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ, 7, 8, 21 дүгээр хороонд шинээр 2.1 км урт урт үерийн хамгаалалтын барилга байгууламж барих, 10, 12 дугаар хороонд үерийн далан засварлаж, шинэчлэх, 4 байршилд ус гаргуурыг шинэчлэх,<br>1, 3 дугаар хороонд 904.5 урт метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. | 100% |
| 4 | Ус ихээр тогтдог болон үер усны аюулд өртөх эрсдэл өндөртэй газрын судалгааг | 30.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, төсөвт санал | Нисэхт 2 байршилд үерийн далан сувгийн | 100% /2 байршилд шаардлагатай | Дүүргийн төсвийн хөрөнгөөр Нисэхийн бүсэд /9 , 10, 16 дугаар хороо/ үерийн ус зайлуулах шугам | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж, шаардлагатай байршилд зураг төсөв хийлгэнэ. | | уламжилсан эсэх, ажлын явц, хувь | зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулагдсан. | байршилд зураг төсөв хийлгэж, төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна./ | сүлжээний зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг "Гидро дизайн иноваци" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зураг батлагдах шатанд хэрэгжиж байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ дүүргийн 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр 1.8 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж барих, 12 дугаар хороонд 180 урт метр Туул голын далан өндөрлөх, эргийн бэхэлгээ хийх ажлыг бүрэн гүйцэтгэсэн, 10 дугаар хороо 300 урт метр Нисэхийн ус зайлуулах сувгийг засварлаж, 4 байршилд ус гаргуурыг шинэчлэх ажил хэрэгжсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7, 8 дугаар хороо, бороо орсны дараа ус хэмжээгээр тогтож, иргэд зорчих боломжгүй болдог 17 дугаар гудамжинд 300 урт метр ус зайлуулах сувгийг шинээр байгуулж, 2 талын шороон замын хусаж, дайргаар засварласан.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3 дугаар хороо Ажилчны гудамжнаас Яармагийн гүүр хүртэл /Шунхлай ШТС/ 705 урт метр авто замын ус зайлуулах шугам тавих, 1 дүгээр хороо, Чимэд-Осорын гудамжинд 199.5 урт метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. | |
| **Зорилт 1.5** Нийтийн эзэмшлийн зам талбайн болон хогийн цэг, хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах | | - | Суурилуулсан камерын тоо, ажлын явц, хувь | 117 камер суурилуулах ажлын кабель татагдсан. | 100% /300-аас доошгүй байршилд камержуулсан байна./ | Нийтийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 5 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 522 ширхэг камер суурилуулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэгүүдийн камержуулалтыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 4.3.2/ | | | | | бөгөөд 2022 онд 127 ширхэг камерыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>Камерын засвар, үйлчилгээний ажлын хүрээнд 1, 5, 7, 8, 13, 14, 15, 18, 19, 20 дугаар хороодод байрлах цэцэрлэг, сургууль орчмын авто замын гарц хэсгүүдэд 64, 1, 8, 9, 10 дугаар хороодын байранд 28 ширхэг хяналтын камер шинээр суурилуулсан. | |
| 5 | Дүүргийн хэмжээнд 300-аас доошгүй камер суурилуулж, хуучирч муудсан камеруудыг сэргээн засварлана. | 1,936.2 /ДОНХС/ | Суурилуулсан камерын тоо, ажлын явц, хувь | 117 камер суурилуулах ажлын кабель татагдсан. | 100% /300-аас доошгүй камер суурилуулагдсан байна./ | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 5 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 522 ширхэг камер суурилуулах бөгөөд 2022 онд 127 ширхэг камерыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/57 дугаар захирамжийн дагуу Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ камерын засвар, үйлчилгээний ажлын хүрээнд 1, 5, 7, 8, 13, 14, 15, 18, 19, 20 дугаар хороодод байрлах цэцэрлэг, сургуулийн ойр орчмын зам гарц дээр нийтийн эзэмшлийн гудамж талбай руу харсан 64 ширхэг гадна, 1, 8, 9, 10 дугаар хороодын байранд 28 ширхэг хяналтын камер шинээр суурилуулсан. | 100% |
| **Зорилт 1.6** Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. /ЗГҮАХ 6.1.6/ | | - | Шинээр тавьсан авто замын урт/км | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.7 км авто зам тавигдсан. | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Хан-Уул дүүрэгт 2022 онд шинээр улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,2 км авто зам ашиглалтад оруулсан. Үүнд:<br>1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хороонд хэрэгжсэн Номин Юнайтед их | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.8 км авто зам ашиглалтад орсон.<br>2. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороо Буянт Ухаа 2 хорооллын урд 0.19 км авто зам, зогсоол орсон.<br>3. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороо Нисэхийн шинэ эцэст 1040 м.кв талбайд нийтийн тээврийн зогсоолыг ашиглалтад орсон.<br>4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 17 дугаар хороо Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх 1 км авто замын хөдөлгөөн нээсэн. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5, 16, 21 дүгээр хороонд он дамжин хэрэгжиж буй 3.2 км авто замын ажлын гэрэлтүүлэг, нэмэлтээр түшиц ханын хийгдэж дууссан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн. | |
| 6 | Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хэсгийг сайжруулах зорилгоор 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. | 4,660.00 /ДТХО/, УНТХО | Шинээр тавьсан авто замын урт/км | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.7 км авто зам тавигдсан. | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Хан-Уул дүүрэгт 2022 онд шинээр улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,2 км авто зам ашиглалтад оруулсан. Үүнд:<br>1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хороонд хэрэгжсэн Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.8 км авто зам ашиглалтад орсон.<br>2. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороо Буянт Ухаа 2 хорооллын урд 0.19 км авто зам, зогсоол орсон. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороо Нисэхийн шинэ эцэст 1040 м.кв талбайд нийтийн тээврийн зогсоолыг ашиглалтад орсон.<br>4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 17 дугаар хороо Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх 1 км авто замын хөдөлгөөн нээсэн. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажуллуулах хүсэлт өгсөн.<br>5. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5, 16, 21 дүгээр хороонд он дамжин хэрэгжиж буй 3.2 км авто замын ажлын гэрэлтүүлэг, нэмэлтээр түшиц ханын хийгдэж дууссан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн. | |
| **Зорилт 1.7** Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. /ЗГҮАХ 6.1.7/ | - | Тохижилт хийгдсэн байршлын тоо, шинээр тавьсан явган хүний болон унадаг дугуйн замын урт | 3 тоглоомын талбай, 3.2 км явган хүний зам, Туул голын эрэг дагуу 1.6 км явган хүний болон унадаг дугуйн зам тавьж, 2 авто зогсоол засварласан. | 8-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн 2021 оны 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 12, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хорооны 13 байршилд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай /гүйлтийн замтай/, чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмж суурилуулан тохижуулах ажлыг хэрэгжүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 2, 11, 12, 16, 17, 20 дугаар хорооны 7 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбайн тохижилтын ажлыг шинээр, 1 дүгээр хороо 14, 15 дугаар байрны 14, 15 дугаар байрны тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулсан хөдөлгөөнийг сайжруулах зориулалт бүхий тусгай тоглоомыг суурилуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шинээр 12 дугаар хороонд 1 3х3 сагсан бөмбөгийн талбай, 20 дугаар хороонд Лавайн худалдааны төвийн зүүн талд сул шороон хөрс бүхий талбайг тохижуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороо Богд хааны ордон музейн зүүн талын хашаа болон 3, 17 дугаар хорооны бусад 2 байршилд газар чөлөөлж,1110 м.кв, Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 3, 11, 19, 20 дугаар хорооны 6 байршилд 2522.8 м.кв талбайд тус тус шинээр явган хүний зам тавьж, 1, 2, 3, 11, 15, 18, 19 дүгээр хорооны 16 байршилд хуучирч эвдэрсэн 2387,8 м.кв талбайн явган замыг шинэчилсэн. Мөн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран 1, 2, 3, 4, 8, 12, 15, 16, 19, 20 дугаар хорооны 30 байршилд 25695.8 м.кв талбайд шинээр явган хүний зам тавьсан. | |
| 7 | Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Чингисийн өргөн чөлөөний явган хүний зам, дугуйн замыг шинэчилнэ. | 1,250.0 /ДТХО/ | Шинэчлэгдсэн явган хүний зам, дугуйн замын урт/км, ажлын явц, хувь | - | 100% /4км-ээс багагүй урт явган хүний болон дугуйн зам шинээр тавьсан байна./ | "Тусгай замын автобус LRT төсөл" хэрэгжихтэй холбоотойгоор Чингисийн өргөн чөлөө болон Наадамчдын авто зам дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх чиглэл өгсөн тул тус арга хэмжээг дүүргийн ИТХ-ийн 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 20 дугаар тогтоолоор 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас хассан. | - |
| 8 | Төвийн хороодын нийтийн эзэмшлийн зам талбай, | 1,398.1 | Засвар, тохижилт | ДТХО-аар 9 байршилд 3.2 км | 8-аас доошгүй байршилд засвар, | Дүүргийн төсвийн 750.0 сая төгрөгийн хөрөнгөөр 2022 онд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | явган хүний замын засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. | /ДТХО, ДОНХС/ | хийсэн байршлын тоо | явган хүний зам шинээр тавьсан. | тохижилтын ажил хийгдсэн байна. | шинээр хэрэгжсэн орон сууц хороолол дундах явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт, тохижилтын төсөл арга хэмжээний хүрээнд 1, 3, 11, 19, 20 дугаар хорооны 6 байршилд 2522.8 м.кв талбайд шинээр явган хүний зам тавих, 2, 11, 15, 19 дүгээр хороонд 6 байршилд хуучирч эвдэрсэн 1327.3 м.кв талбайн явган замыг шинэчлэх, 19, 20 дугаар хорооны 2 байршилд авто зогсоол байгуулах, 11 дүгээр хороонд тохижилт 500м.кв талбайг тохижуулах, 17 дугаар хороо, 64 дүгээр байрны гадна талбайд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах, сагсан бөмбөгийн талбайг засварлаж, шинэчлэх ажлын тус тус хэрэгжүүлсэн.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих Дунд гол гудамжны авто замын хойд хэсгийн явган замыг шинэчлэх, 11 дүгээр хороо Мал эмнэлэгийн автобусны буудлын тохижилт, 18 дугаар хороо 29, 30 дугаар байрны гадна талбайн тохижилт, 20 дугаар хороо 27/1 дүгээр байрны тоглоомын талбайн засвар, шинэчлэлтийн ажил зураг төсөл боловсруулах шатанд хэрэгжиж байна.<br>Төсвийн хөрөнгө оруулалтаар болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 12, 15, 16, 19, 20 дугаар хороонд 30 байршилд 25695.8 м.кв талбайд шинээр явган хүний зам тавьсан.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эвдрэлтэй явган хүний замыг нөхөж засварлах ажлыг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т даалган, хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 1, 2, 3, 11, 15, 18, 19 дугаар хорооны 9 байршилд 860,5 м.кв явган хүний замыг засварласан байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1, 3, 17, 19 дүгээр хорооны 4 байршилд газар чөлөөлж 1407 м.кв явган хүний зам талбайг засварлан шинэчилж, 4, 5, 6, 7, 8 дугаар хороо Наадамчдын зам дагуу 165.6 м.кв явган хүний замыг нөхөж, засварласан. | |
| 9 | 1, 2, 3, 4, 10, 12, 14, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хороодод хийгдэж буй орчны тохижилтын ажлыг дуусган, ашиглалтад оруулна. | 1,394.4 /ДТХО/ | Тохижилт хийсэн байршлын тоо | Тохижилтын ажлын гэрээ байгуулагдсан. | 15-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн 2021 оны 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 12, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хорооны 13 байршилд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай /гүйлтийн замтай/, байгуулах, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах, 15 дугаар сургуулийн хашаа барих, 14 дүгээр хорооны 3 байршилд явган хүний гүүрэн гарц барих, 15 дугаар хороо, Хурд Рапид хороолол, 17, 19 дүгээр байрны голын талбайн буулгалт, ашиглалттай дээврийн засварлах ажлыг тус тус хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан. | 100% |
| 10 | Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талд "Өглөөний гудамж" байгуулж, Хан-Уул | 980.0 /ДТХО/ | Өглөөний гудамж байгуулагдсан эсэх, ажлын явц, хувь | - | 100% /Өглөөний гудамж байгуулагдсан байна./ | Өглөөний гудамж байгуулах ажлыг дүүргийн ИТХ-ийн 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 20 дугаар тогтоолоор 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өндөрлөг орчмыг тохижуулна. | | | | | хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас хассан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр "Өглөөний гудамж байгуулах ажил"-ын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Скайлайн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Зураг төсөвд магадлал хийлгүүлж хүлээлгэн өгсөн. | |
| **Зорилт 1.8** Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. /ЗГҮАХ 6.2.6/ | | - | Санал асуулга зохион байгуулсан эсэх | Цахим санал асуулга 63 хувьтай явагдсан. | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд e-mongolia болон ОНХС-ийн цахим системээр дамжуулан зохион байгуулсан. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, "e-mongolia", "Орон нутгийн хөгжлийн сан" аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хороо тус бүрт 140 ширхэг тараах материал хүргүүлж, "Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга" удирдамж батлан зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд уралдаан зарлан шалгаруулж, Хан-Уул дүүргийн хэмжээнд 18-аас дээш насны иргэдээс санал авсан. | 100% |
| 11 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, | УА-ны зардлаар | Цахим санал асуулга зохион | Цахим санал асуулга 63 хувьтай явагдсан. | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахим аппликейшн ашиглан зохион байгуулна. | | байгуулсан эсэх | | | цахимаар санал авах ажлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, "e-mongolia", "Орон нутгийн хөгжлийн сан" аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хороо тус бүрт 140 ширхэг тараах материал хүргүүлж, "Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга" удирдамж батлан зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд уралдаан зарлан, идэвхи санаачлагатай ажилласан 3 зохион байгуулагч, 7 хэсгийн ахлагч буюу нийт 10 албан хаагчийг шалгаруулж, дүүргийн Засаг даргын Тамгын Газрын даргын "Талархал" гардуулсан. Хан-Уул дүүргийн хэмжээнд, 15 төсөл арга хэмжээнд нийт 102,384 санал авсан. Хамгийн олон санал авсан 3 төсөл, арга хэмжээг дурдвал:<br>Ахмад настан болон хүүхэд, залуучуудад зориулсан тоглоомын болон биеийн тамир чийрэгжүүлэлтийн талбай байгуулах-10,677 санал<br>Гудамж талбайн камержуулалт хийх-10,191 санал<br>Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх 7,909 саналтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.9** Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.1/ | | - | Агаарын бохирдлыг бууруулсан хувь | 2018-2020 онд агаарын бохирдол 60 хувиар буурсан. | 2021-2024 онд агаарын бохирдлыг тодорхой хувиар буурсан байна. | Дүүргийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд 53 цэгээр дамжуулж гэр хорооллын иргэдийг 32,147.3 тн сайжруулсан шахмал түлшээр хангасан. | 100% |
| 12 | Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. | - | Хангамжийн бааз, борлуулалтын цэгийн тоо | 1 хангамжийн бааз, 53 борлуулалтын цэг байгуулсан. | 1 хангамжийн бааз, 50-аас доошгүй борлуулалтын цэг байгуулна. | Сайжруулсан шахмал түлшний 53 цэг ажиллаж, өдөрт дунджаар 5 тонн түлш түгээлтээр ирж борлуулагдаж байна. 2022 онд нийт 323498тн сайжруулсан шахмал түлш түгээлтээр ирж, 321473 тн сайжруулсан шахмал түлш борлуулагдсан байна. Дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш нөөцлөх 7 агуулахад 11120 тн сайжруулсан шахмал түлш нөөцөлсөн. Дүүргийн алслагдсан хороод буюу 13, 14 дүгээр хороодод 2 борлуулалтын цэг нэмж ажиллуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна. | 100% |
| 13 | Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Уурын зуухны халаалттай байгууллагуудыг төвлөрсөн халаалтын шугамд холбох ажлыг эхлүүлсэн байна. | Дүүргийн 6 дугаар хороонд байрлах "Хоёулаа миний хүү" ХХК-ны зуухнаас халаалт авдаг 6 дугаар хорооны байр, Цагдаагийн 2-р хэлтэс, дүүргийн нэгдсэн амбулатор, Шуудан холбоо зэрэг байгууллагууд "Цэвэр агаар" төслийн санхүүжилтээр 2022 онд төвлөрсөн халаалтад шилжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажил хангагдаж байсан боловч зураг төсөв батлаагүй учир төвлөрсөн шугамд холбогдоогүй, уурын зуухаар халаалтаа авч байна. | - |
| 14 | Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион | - | Тооллого зохион байгуулж, | Тооллогыг 1 удаа зохион байгуулж, | Мэдээллийн сан шинэчилсэн байна. | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, ердийн зуухтай гэрт амьдардаг 4420 өрх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна. | | цахим бүртгэлийн санд оруулсан эсэх | цахим бүртгэлийн санд оруулсан. | | ердийн зуухтай байшинд амьдардаг 5688 өрх, сайжруулсан зуухтай гэрт амьдардаг 2848 өрх, сайжруулсан зуухтай байшинд амьдардаг 3877 айл өрх, 16-100 кВт хүчин чадалтай нам даралтын зуухтай 116 аж ахуйн нэгж байгууллага, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 18 уурын халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг шинэчлэн оруулсан. | |
| 15 | Гэр хорооллын айл өрхүүдийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдээлэл хүргэх ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 3, 4, 9, 10 дугаар сард угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг 18000 айл өрхөд хүргэх ажлыг зохион байгуулсан. | Галлагааны улиралд угаарын хийн хордлогоос сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж 18000 өрхөд хүргэнэ. | Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар анги, Улаан загалмайн хороо, хороодтой хамтарч угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх 3 удаагийн аян, арга хэмжээг зохион байгуулж, гэр хороолол бүхий 12 хорооны иргэдэд 34052 ширхэг гарын авлага, зөвлөмжийг хүргүүлж, 975 ширхэг зурагт зөвлөмжийг зах худалдааны төв, халуун ус, хорооны байранд байршуулах, гал унтраах ангийн автомашинаар дуут дохио, зөвлөмж хүргүүлэх арга хэмжээг тус тус авч ажилласан. | 100% |
| 16 | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын уурын зуухнуудад хяналт шалгалтыг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо | 18 халаалтын зууханд хяналт шалгалт зохион байгуулсан. | 18 тусгай зөвшөөрөлтэй уурын зуухнуудад хяналт шалгалт хийнэ. | Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулж, дүүргийн хэмжээнд 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч, дулаан, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 18 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжилсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 арга хэмжээ зохион байгуулсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Нийслэлийн Засаг даргын А/1029 дүгээр захирамжийн хүрээнд байгальд ээлтэй дэвшилтэт технологийг сурталчлах, угаарын хийн хордлогын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Байгальд ээлтэй дэвшилтэт технологи" өндөрлөгийг дүүргийн хэмжээнд гэр хорооллын хороодыг 3 бүсэд хуваан зохион байгуулсан. Өдөрлөгт "Мон ватт" ХХК, "Мөнхийн амар дулаан" ХХК, "Корей кабель" ХХК "Өлзий зуух" ХХК "Таван толгой түлш" ХХК-ийн Хан-Уул дүүргийн иргэдэд үйлчлэх төв, "Дөл зуух" ХХК, "Мега хэт" ХХК оролцож, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14 дүгээр хороодын 2000 гаруй иргэд оролцож, 6,264,000 төгрөгийн байгальд ээлтэй худалдан авалт хийсэн. | 100% |
| **Зорилт 1.10** Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.4/ | | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 850 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1000-д хүргэнэ | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо 1304 болж нэмэгдсэн. | 100% |
| 18 | Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 850 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1000-д хүргэнэ | Дүүргийн гэр хорооллын "Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага MNS 5924:2015" стандарт бүхий гэр хороолол, зусланд хэрэглэх зориулалттай нүхэн жорлонгийн 4 хувилбарын талаарх мэдээллийг агуулсан 1 видео шторкийг дүүргийн болон хороодын цахим хуудаст байршуулан иргэдэд сурталчилсан. Гэр хорооллын хороодод барьсан стандартын бус нүхэн жорлонг 2021 онд 13855 байсныг 2022 онд 10475 болгож 3380 ширхэгээр бууруулсан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо 1304 болж нэмэгдсэн бөгөөд тус судалгааг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.<br>Улсын төсвийн 896,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 8, 9, 10 дугаар хорооны 525 өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй нүхэн жорлонгоор шинэчлэх ажил 2021 онд эхэлж, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 8 дугаар хороонд хийгдэх нийт 110 эко нойлын 110 нүхийг ухсанаас 60 нүхэнд кольцо суулгасан, бүрэн дууссан 1 ширхэг, 9 дүгээр хороонд хийгдэх нийт 305 эко нойлын 305 нүх ухсаны 52 нүхэнд кольцо суулгасан, 10 дугаар хороонд хийгдэх нийт 135 эко нойлоос 119 нүх ухсаны 52 нүхэнд кольцо суулгасан, бүхээг тавьсан 18 ширхэг байна. | |
| **Зорилт 1.11** "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ./ЗГҮАХ1.1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдаас бүрдсэн тандалт, шуурхай хариу арга хэмжээний 3 баг, шуурхай штабын 1 баг, Туул тосгоны 80 ортой түр эмнэлэг, Нэгдсэн эмнэлгийн 150 ортой ковидын эмнэлгийн шуурхай багууд 24 цагаар ажиллаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. 2022 оны 7 дугаар сараас өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас 1-2 алба хаагч, нэмэлтээр резидэнт эмч нарыг дайчилж, ковидын амбулаторийг ажлын өдрүүдэд 08:00-20:00 цаг, амралтын өдрүүдэд 9:00-15:00 цаг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүртэл ажиллуулсан. 2022 онд дүүргийн хэмжээнд 34301 иргэн халдвар авч, 29425 иргэн гэрийн эмчилгээнд өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтад эмчлүүлсэн. ХӨСҮТ, ЭНЭҮТ болон дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 4784 иргэн хэвтэн эмчлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Дүүргийн хэмжээнд 2022 онд "Ковид-19" халдварын эсрэг дархлаажуулалтын 11 цэгийг ажиллуулж, 1-р тунд 761, 2-р тунд 991, 3-р тунд 10136, 4-р тунд 11083, 5-р тунд 115 иргэнийг хамруулж өссөн дүнгээр 1-р тунд 153,188,761, 2-р тунд 160,145,991, 3-р тунд 77,538, 4-р тунд 11,214, 5-р тунд 158 иргэн хамрагдсан. | |
| 19 | "Ковид-19" цар тахлын үед дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлан ажиглах байраар ашиглах боломжтой объектын судалгаа, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг тогтмол гаргаж хянана. | - | Шинэчилсэн судалгааны тоо | 7 төрлийн судалгаа гаргасан. | 5-аас дээш удаа судалгааг шинэчлэн гаргаж, баяжилт хийнэ. | "Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг хангаж 3-6 сарын нөөц бүрдүүлэн ажилласан. "Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамжийн нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын дагуу burtgel.mohs.mn програмд бүртгэл хөтөлж хэвшсэн. Эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийт 60 орчим сая төгрөгийн нөөц бүрдүүлэн ажилласан.Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн эмнэлэг, эмийн сангийн судалгааг шинэчлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гаргасан. Судалгаагаар улсын эмнэлэг-4, хувийн эмнэлэг-105, эмнэлгийн нийт орны тоо-1990, нийт их эмчийн тоо-440, эмийн сан-150 бүртгэгдсэн. | |
| **Зорилт 1.12** "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 2.1.1.7/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулахаар холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллах 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 193, 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 200 дугаар албан бичгийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | 30% |
| 20 | Дүүргийн Эрүүл мэндийн төвд Эрэгтэйчүүдийн кабинет байгуулна. | - | Кабинет байгуулсан эсэх, гүйцэтгэлийн хувь | НЭМГ-ын 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн. | Кабинет байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулахаар холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллах 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 193, 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 200 дугаар албан бичгийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.<br>"Эрэгтэйчүүдийн кабинет"-ыг байгуулахтай холбогдуулан эмч, сувилагч нарыг сургалтад хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан. 2023 оны хөрөнгө оруулалтын саналд "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулах саналыг хүргүүлсэн. | 30% |
| **Зорилт 1.13** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 8-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | 2022 онд нийтийн биеийн тамирын чиглэлээр "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аянд 28636 иргэн, "Улаанбаатар марафон-2022" олон улсын гүйлтэд 3014 иргэн, "Автомашингүй өдөр" 3000 иргэн, "Хамтдаа алхаад эрүүлжье" аянд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.1/ | | | | | | 2100 гаруй иргэд, "Алхацгаая гүйцгээе" явган алхалтад 61 байгууллагын 1870 албан хаагч, дүүргийн "Улаанбаатар лиг" гар бөмбөгийн фестивальд 950 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын тэмцээнд 1000 багш, "Улаанбаатар марафонд нэгдэцгээе" аянд 6097, Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын аянд 3766 албан хаагч, Иргэдийн спортын X наадам 5880 иргэн, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 16 арга хэмжээнд 510 иргэн гэх мэт улс, нийслэл, дүүргээс зохион байгуулсан нийт 92 арга хэмжээнд 125286 иргэнийг хамруулсан. | |
| 21 | "Иргэдийн спортын Их наадам"-ыг спортын 8 төрлөөр зохион байгуулна. | - | Хамрагдсан иргэдийн тоо | 860 иргэнийг хамруулсан. | Спортын 8 төрөлд иргэдийг хамруулна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит Иргэдийн спортын X их наадмыг спортын 8 төрлөөр (явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, гарбөмбөг, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагай наадгай) хороо, дүүргийн хэмжээнд 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Дүүрэгт шилдгээр шалгарсан 4 хорооны баг, тамирчид Нийслэлийн Иргэдийн спортын их наадамд амжилттай оролцож, 4 алт, 2 мөнгө, 2 хүрэл, нийт 8 медаль хүртэж багийн нэгдсэн дүнгээр "Тэргүүн байр"-нд шалгарсан. Иргэдийн спортын X наадамд давхардсан тоогоор 5880 иргэнийг хамруулсан. | 100% |
| **Зорилт 1.14** Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 5 арга хэмжээ зохион байгуулж, 459.1 тн мах, 920 тн хүнсний ногоо худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мах, ногооны чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. | |
| 22 | Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавина. | 3000.0 | Зохион байгуулсан арга хэмжээ, хяналт шалгалтын тоо | 3 арга хэмжээ зохион байгуулж, хяналт тавина ажилласан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, хяналт тавина ажиллана. | Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:<br>Нөөцийн махны худалдааг 48 хүнсний дэлгүүр, 12 сүлжээ дэлгүүрээр 135,6 тонн мах, өргөтгөсөн худалдааг 2 дугаар улирлын амралтын өдрүүдэд давхардсан тоогоор 39 байршилд 323,5 тн, нийт 459.1 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодтой хамтран махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан.<br>Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг давхардсан тоогоор 10 байршилд зохион байгуулж, 130 газар тариалан эрхлэгч 920тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулсан байна. | 100% |
| **Зорилт 1.15** Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 3.3.13/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Үйлдвэрлэл эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Хан-Уул дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх шаардагдах төсөвт өртөг бүхий төслийг боловсруулж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. | 100% |
| 23 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн | 35 сая | Байгуулсан цэг, дэмжин ажилласан үйлдвэрлэл | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | 1-2 цэг байгуулж, 20-30 үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжсэн байна. | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд:<br>Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, худалдааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | худалдааны 1-2 цэг байгуулж, борлуулалтыг дэмжин ажиллана. | | эрхлэгчийн тоо | | | гудамж байгуулах зорилгоор "Амралтын өдрийн худалдаа" арга хэмжээг нийт 5 удаа зохион байгуулж бизнес эрхлэгчдийг дэмжин ажилласан. Уг арга хэмжээнд дүүргийн 58 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 40,5 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан 11 удаагийн үзэсгэлэн худалдаанд 102, нийт 160 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж; нийлбэр дүнгээр 243.5 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлсэн. | |
| **ХОЁР. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 2.1** Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана. /ҮХ 2.1/ | | | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хамрагдсан албан хаагчийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан. | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж,төлөвлөгөөг 100% хэрэгжүүлнэ. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулсан. Мөн Шударга ёс, хөгжил дэвшилд уриатай "Авлигыг мэдээлэх утас 110" постерийг байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. | 100% |
| 24 | Авлигын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, иргэд, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалт,арга хэмжээ хамрагдсан албан хаагч, иргэдийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан. | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө 90-100 хувьтай хэрэгжсэн байна. | Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөг 85 хувь хэрэгжүүлэн ажилласан. Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны дарга нар, орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд нийт 31 албан тушаалтныг Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд оролцуулсан. Авлигатай тэмцэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх нь" сэдэвт цахим сургалтад 45, танхимын сургалтад 4 албан хаагчийг тус тус хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Шударга байдлын үнэлгээ 2022" судалгаанд байгууллагын 30 албан хаагч болон Засаг даргын Тамгын газартай хамтран ажилладаг 20 байгууллага, албан хаагчаас шинжээчийн судалгаа авч холбогдох байгууллагад хүргүүлсэн. | |
| **Зорилт 2.2** "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй авах ногоочдын хүсэлтийн дагуу 250 өрхөд хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. | 100% |
| 25 | Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан | Өрхийн тариалалт нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр:<br>• Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны 250 өрхөд 2.2 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны үрийг олгож, тариалалтыг дэмжин ажилласан.<br>• Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг давхардсан тоогоор 10 байршилд зохион байгуулж; 130 газар тариалан эрхлэгч 920тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулсан байна.<br>• Дүүргийн хэмжээнд 2022 онд нийт 181.2га талбайгаас 2805тн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ургац хураан авсанаас ил талбайгаас 2940тн, хамгаалагдсан хөрс буюу хүлэмжнээс нийт 347.6тн ургац тус тус хураан авч, ургац хураалтын ажилд хяналт тавин ажилласан.<br>• Төмс, хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг 12 иргэн ААН-ийн 146.3тн хүнсний ногоонд олгож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллаж байна.<br>• Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй иргэдэд мэргэжлийн байгууллагатай хамтран 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 137 тариалан эрхлэгч хамрагдсан.<br>Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" 3 хувийн хүүтэй зээлд хамрагдах хүсэлтэй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмж, үр тариа, тос тэжээлийн таримлын тариалалтын үйлдвэрлэл эрхэлдэг 477 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, ХХААХҮЯ-д хүргүүлж ажилласан. | |
| **Зорилт 2.3** Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт тооцох, тайлагнах ажлыг зохион байгуулна. | | - | Хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэсэн. | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор Үндэсний хөтөлбөрийг хүчингүй болгосон. | - |
| 26 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, холбогдох хэлтэс албадаас тайланг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | - | Хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэсэн. | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | | |
| **ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 3.1** Хүүхдийн зуслан, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, иргэдийн эрүүл | | - | Зураг төсөв хийлгэж, санал | 1 байршилд зуслангийн архитектур | 2 байршилд зуслангийн зураг төсвийг хийлгэж, | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу гэр бүл амрах | 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. /НЗДҮАХ 5.1.1.1/ | | уламжилсан эсэх. | төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | төсөвт санал уламжилна. | зориулалт бүхий "Эко зуслан"-ийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Эрхэс констракшн ХХК шалгаран гэрээ байгуулсан. Загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Нийт 402 айлын орон сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж төлөвлөгдсөн. "Эко зуслан"-ийн ажлын зураг боловсруулагдаж байна. Дүүргийн 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакумжуулсан сургалттай хүүхдийн зуслангийн зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 90 хувьтай. Дээрх 2 төсөл, арга хэмжээг 2023 оны дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналын жагсаалтад тусгасан. | |
| 27 | 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакуумжуулсан сургалттай хүүхдийн зуслан, 14 дүгээр хороонд залуу гэр бүлд зориулсан эко зуслангийн зураг төсвийг хийлгэнэ. | 100.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан эсэх. | 1 байршилд зуслангийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | 2 байршилд зуслангийн зураг төсвийг хийлгэж, төсөвт санал уламжилна. | Дүүргийн 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакумжуулсан сургалттай хүүхдийн зуслангийн зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Загвар зураг батлагдаж, ажлын зураг боловсруулагдаж байна. Ажлын явц 90 хувьтай.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу гэр бүл амрах | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулалт бүхий "Эко зуслан"-ийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Эрхэс констракшн" ХХК шалгаран гэрээ байгуулсан. Загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Нийт 402 айлын орон сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж төлөвлөгдсөн. "Эко зуслан"-ийн ажлын зураг боловсруулагдаж байна. Дээрх 2 төсөл, арга хэмжээг 2023 оны дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналын жагсаалтад тусгасан. | |
| 28 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 5-аас доошгүй байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэг, ойн төглийг байгуулна. | 1,200.0 /УТХО/ 2,180.0 /ДТХО/ | Шинээр байгуулсан бичил цэцэрлэг, ойн төглийн тоо | 1 цэцэрлэгт хүрээлэн, 9 бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. | 5-аас доошгүй байршилд цэцэрлэгжүүлэлт тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. | Иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх, амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 3, 11, 15, 19, 21 дүгээр хорооны 5 байршилд ногоон байгууламж, амралтын талбай, тоглоомын талбай бүхий тохижилт, 2 дугаар хорооны 2 байршилд */2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд/* авто зогсоол, дугуйн зам, явган хүний зам, чийрэгжүүлэлтийн талбай, ногоон байгууламж бүхий тохижилт, 2, 16 дугаар хорооны 2 байршилд тоглоомын талбайн тохижилт, 1, 13, 21 дүгээр хорооны 5 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, 34, 52 дугаар сургуулийн гадна талбайд олон улсын стандартад нийцсэн 2 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөлбөмбөгийн талбай байгуулах ажил хэрэгжсэн. Дүүргийн 2021 оны 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 12, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хорооны 13 байршилд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай /гүйлтийн замтай/, чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмж суурилуулан тохижуулах ажлыг хэрэгжүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 2, 11, 12, 16, 17, 20 дугаар хорооны 7 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбайн тохижилтын ажлыг шинээр, 1 дүгээр хороо 14, 15 дугаар байрны 14, 15 дугаар байрны тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөдөлгөөнийг сайжруулах зориулалт бүхий тусгай тоглоомыг суурилуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шинээр 12 дугаар хороонд 1 3х3 сагсан бөмбөгийн талбай, 20 дугаар хороонд Лавайн худалдааны төвийн зүүн талд сул шороон хөрс бүхий талбайг тохижуулсан. | |
| **Зорилт 3.2** Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжиж ажиллана. /НЗДҮАХ 5.1.1.4/ | | 1,000.0 /ДТХО/ | Тарьсан мод, бут, сөөгний тоо | 2000 ширхэг жимсний мод, бут, сөөг тарьсан. | 10,000-аас доошгүй мод, бут, сөөг тарина. | Дүүргийн 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1300 хашаанд 10,143 ширхэг мод, бут сөөгийг шинээр тарьсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Гэр хорооллын айл өрхүүдтэй хамтарч мод, бут, сөөг тарьж, ургуулах арга хэмжээ авч ажиллана. | 1,000.0 /ДТХО/ | Тарьсан мод, бут, сөөгний тоо | 2000 ширхэг жимсний мод, бут, сөөг тарьсан. | 10,000-аас доошгүй мод, бут, сөөг тарина. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн зохион байгуулсан. Тус аяны хүрээнд тус дүүргийн төсвийн хөрөнгөөр 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 800 өрхтэй хамтарч, 7643 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, өрх тус бүрт мод тарих хялбаршуулсан аргачлал бүхий гарын авлага, гэрчилгээг олгосон. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр Дэвшилтэт Социал демократ клубээс хэрэгжүүлж буй Cleanup төслийн хүрээнд 9, 10, 16 дугаар хорооны 500 өрхтэй хамтарч, 2500 ширхэг мод, бут тарьж, 4 талт гэрээ байгуулсан. | 100% |
| **Зорилт 3.3** Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно. /НЗДҮАХ6.3.30/ | | - | Шинээр суурилуулсан гэрэлтүүлгийн тоо, ажлын явц, хувь | Нийт 13 хороонд 494 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан. | Нийтийн эзэмшлийн талбайд 400-аас доошгүй байршилд гэрэлтүүлгийг суурилуулсан байна. | Дүүргийн 2, 3, 4, 11, 13, 14, 15, 17, 19, 20, 21 дүгээр хороонд шинээр 494 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан. | 100% |
| 30 | Хороодын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хороололд 400-аас доошгүй гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ. | 1,192.0 /ДТХО/ | Шинээр суурилуулсан гэрэлтүүлгийн тоо, ажлын явц, хувь | Нийт 13 хороонд 494 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан. | Нийтийн эзэмшлийн талбайд 400-аас доошгүй гэрэлтүүлгийг суурилуулсан байна. | Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.<br>Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний хүрээнд 4420 метр кабель шугам, 1740 ширхэг гэрэлтүүлэг, 446 ширхэг гэрэлтүүлгийн шон, 211 ширхэг цахилгааны самбарын хайрцагт засвар, 68 ширхэг гэрэлтүүлгийн шон будах ажил үйлчилгээ хийсэн байна. Мөн 120 мянгатын цэцэрлэгт хүрээлэнгийн нэмэлт гэрэлтүүлэг хийж талбайн хэсгийг бүрэн гэрэлтүүлсэн, 19-ийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээний төвийн авто зам болон арьс ширний гудамны гэрэлтүүлгүүд нь бүдэг натри гэрэлтүүлэгч байсныг 100вт-ийн лед гэрлээр бүрэн сольж шинэчилсэн.Асалт 96 хувь. | |
| **Зорилт 3.4** Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох "Зөв шийдэлтэй" дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ. /НЗДҮАХ 6.1.7/ | - | Ажлын явц, хувь | - | Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана. | Хан-Уул дүүргийн 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.9 га талбай буюу 5791 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Үүнд:<br>• 4 дүгээр хороо 34-р сургууль орчим 16.5 га 159 нэгж талбарт "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ 3 талт гэрээ байгуулалт ажлын явц 85% буюу 136 нэгж талбарын иргэдтэй байгуулан 108 нэгж талбар газар чөлөөлсөн. Үүнээс: Буянт ухаа 1 орон сууцны хороололд-17 нэгж талбар, Буянт-Ухаа 2 хороололд-65 нэгж талбар нийт 82 нэгж талбарын иргэдэд орон сууц олгосон. 26 нэгж талбарт түрээсийн зардал олгож байна. Е-хэсэг 39.9 га 938 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 60% буюу 616 нэгж талбарын иргэдтэй байгуулсан, нийт 118 нэгж талбарт газар чөлөөлөлт хийгдэж 3 блок 360 айлын орон сууц ашиглалтад орсон.<br>• 5 дугаар хороо Д хэсэг 34 га 810 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц-10% буюу 80 нэгж талбарын иргэдтэй байгуулсан. 2023 оны 05 дугаар сард барилга угсралтын ажил эхлэнэ, 41-р сургууль орчим 10.55 га 153 нэгж | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талбар "Ама констракшн" ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 60% буюу 93 нэгж талбарын иргэдтэй байгуулсан, эхний ээлжийн 11 нэгж талбарт газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн.<br>• 6 дугаар хороо Г хэсэг 54.5 га 1200 нэгж талбарт "Голден мартин" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10% буюу 118 нэгж талбарын иргэдтэй байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн зураг 95%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.<br>• 7 дугаар хороо В хэсэг 40.9 га 630 нэгж талбарт "Ланкастер" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 11.5% буюу 72 нэгж талбарын иргэдтэй байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2022оны 09 дүгээр сарын 20-нд батлуулсан.<br>8 дугаар хороо А хэсэг 45.9 га 756 нэгж талбарт "Монголиан инвестмент кропорешн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10% буюу 68 нэгж талбарын иргэдтэй байгуулсан, Мөн А хэсэг 11.5 га, 134 нэгж талбарт "Ажнай цэпц" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 80% буюу 107 нэгж талбарын иргэдтэй байгуулсан эхний ээлжийн 7 нэгж талбарт газар чөлөөлөлтийн ажил хийгдэж 2 блокт 192 айлын орон сууцны барилгын суурийг тавьж, барилга угсралтын ажил эхэлсэн. Б-хэсэг 46.1 га 788 нэгж талбарт "Ивээлт цамхаг констракшн" ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 30-40% буюу 234 нэгж талбарын иргэдтэй байгуулсан, эхний ээлжийн 15 нэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбарт газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн. Барилгажих хэсгийн техникийн нөхцөл хүссэн. Мөн Б-хэсэг 15 га талбайд "Баярс ХХК" ажлыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/156 дугаар захирамжаар батламжийг цуцалсан. 2023 онд тус байршилд төслийн сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна. | |
| 31 | Гэр хорооллын иргэдэд дахин төлөвлөлтийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, иргэдийн хүсэлтийг холбогдох байгууллагуудад уламжлан хамтран ажиллана. | ҮА-ны зардлаар | Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувь | Ковидын улмаас сургалт, арга хэмжээ зохион байгуулаагүй. | Сургалт, уулзалт зохион байгуулсан байна. | "Нийслэлийн орон сууц бодлогын газар"-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр дүүргийн 5 дугаар хорооны иргэдэд, 2022 оны 04 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд дүүргийн 6, 7, 8 дугаар хорооны оршин суугч иргэдэд Яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн явцын талаарх мэдээллийг бэлтгэн 4 удаагийн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. Мөн 2022 оны 09 дүгээр сарын 9-ны өдөр дүүргийн удирдлагууд Нийслэлийн орон сууц бодлогын газрын холбогдох албан тушаалтнуудтай гэр хорооллын дахин төлөвлөлтийн явц, цаашид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар санал солилцсон. | 100% |
| **Зорилт 3.5** Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцнуудыг үе шаттайгаар шинэчилнэ. /НЗДҮАХ 6.1.9/ | | - | Ажлын явц, хувь | - | Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана. | Дүүргийн АШХНЗОС-ны 34 барилга байгаагаас 29 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 615 айлын 23 орон сууцыг буулган 1539 айлын 10 орон сууц ашиглалтад оруулж, 444 айлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангасан. 2022 онд АШХНЗОС дахин барилгажуулах ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:<br>• ХУД 01-р багц "Фужи | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | девелопмент" ХХК Нэхмэлийн 11, 16 дугаар байр буулган барилгын суурийн ажил хийгдэж дууссан. Суурийн цутгалтын ажил хийгдсэн<br>• ХУД 02-р багц "Харү констракшн" ХХК Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байр буулгалтын ажил хийгдсэн.<br>• ХУД 02-р багц "Эм Эм Жи Капитал" ХХК АШҮН 26, Нэхмэлийн 3-р байр, 36 айлын орон сууцыг буулган 253 айлын 1 орон сууц ашиглалтад оруулсан.<br>• ХУД 10-р багц "Шинэ гэр түншлэл" ХХК 36А, 36Б дугаар байрны дахин төлөвлөлтийн ажил зогссон шүүхийн маргаантай байна.<br>• ХУД 11-р багц<br>Монтекарло гоулд" ХХК Нийслэлийн Засаг даргын А/80 дугаар захирамжаар батламжаа авсан. Сүрьеэгийн 20 дугаар байрны дахин төлөвлөлтийн ажлын 3 талд гэрээ байгуулах ажил 80%-тай буюу 31 айлтай гэрээ байгуулсан. 2022 онд Хан-Уул дүүргийн 3, 10, 12 дугаар хорооны 5 ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтай орон сууцны 1,13 га нэгж талбарт төслийн сонгон шалгаруулалтыг нэг удаа зарласан. Үүнд: /ХУД-06-р багц 10 дугаар хорооны Нисэхийн 34, 35 дугаар байр 0.52 га, ХУД-08-р багц 12 дугаар хорооны Биокомбинатын 39 дүгээр байр 0.26 га, ХУД-09-р багц 3 дугаар хорооны Арьс ширний 31 дүгээр байр 0.2 га, ХУД-13-р багц 3 дугаар хорооны Талхны 20 дугаар байр 0.15 га/. Тус сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгараагүй.2023 онд төслийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна. | |
| 32 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны оршин суугч иргэдэд дахин төлөвлөлтийн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | УА-ны зардлаар | Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувь | Ковидын улмаас сургалт, арга хэмжээ зохион байгуулаагүй. | Сургалт, уулзалт зохион байгуулсан байна. | "Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар"-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Сүрьеэгийн 20 дугаар байрны 45 оршин суугч иргэдтэй, "Нийслэлийн орон сууцны корпораци"-тай хамтран 10 дугаар хороо 34, 35 дугаар байрны 96 оршин суугч иргэдтэй 2022 оны 09 дүгээр сарын 20, 2022 оны 11 дүгээр сарын 1, 4-ний өдрүүдэд тус тус дахин төлөвлөлтийн ажлын явцын талаарх мэдээлэл өгөх, санал солилцох уулзалтыг нийт 4 удаа зохион байгуулсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын дагуу 1 дүгээр хороо 18, 19, 20,21,21-дугаар байр, 3 дугаар хороо Хараагүйчүүдийн 48 дугаар байр, 7 дугаар хороо 16 дугаар байр, 20 дугаар хороо дэвшлийн 36 дугаар байрны оршин суугчдаас саналыг авч нэгтгэн "Хот байгуулалт хөгжлийн газар" уламжилсан. | 100% |
| 33 | Нийтийн зориулалттай хуучин орон сууцны дээвэр, фасадыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн, шинэчилсэн байна. | 1,927.0 /ДТХО/ | Засварласан байрны тоо, засварын ажлын явц, хувь | 2021 онд 9 байрны дээвэр, 1 байрны фасад засварласан. | 4 байрны дээвэр, 3 байрны фасадны засварыг хийсэн байна. | Дүүргийн 2021 оны төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хороо 25 дугаар байр, 13 дугаар хороо 5 дугаар байрны дээврийн засварын ажлыг гүйцэтгэж ашиглалтад хүлээж авсан.<br>Дүүргийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 8а байр, 30 дугаар байр, 10 дугаар хорооны 2, 61 дүгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байруудын фасад засвар, дулаалгын ажлыг хийж гүйцэтгэж, ашиглалтад хүлээж авсан; Дүүргийн төсвийн 627,0 сая хөрөнгөөр хэрэгжих 3 дугаар хороо 1а байр, 10 дугаар хороо 60, 63, 61/1, 61/2, 67 дугаар байр, 15 дугаар хороо Жаргалан 60 дугаар байр нийт 7 байрны дээвэр засварын ажил бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 13 дугаар хороонд 2 дугаар байрны дээврийн засварын ажил хэрэгжиж дууссан. | |
| **Зорилт 3.6** Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллана. | | - | Төлөвлөсөн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | ЗГҮАХ-ын 2021 оны биелэлт 96.3, НЗДҮАХ-ын 2021 оны биелэлт 92.1 хувьтай хэрэгжсэн. | Хангалттай түвшинд хэрэгжсэн байна. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 92.5 хувьтай, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай тус тус хэрэгжсэн. | 100% |
| 34 | Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэгтэй хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, улирал тутам тайлагнаж ажиллана. | ҮА-ны зардлаар | Төлөвлөсөн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | ЗГҮАХ-ын 2021 оны биелэлт 96.3, НЗДҮАХ-ын 2021 оны биелэлт 92.1 хувьтай хэрэгжсэн. | Хангалттай түвшинд хэрэгжсэн байна. | "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2022 оны төлөвлөгөөний 2 бүлэг, 3 зорилт, 5 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.5 хувьтай хэрэгжсэн бөгөөд удаашралттай хэрэгжиж байгаа арга хэмжээ байхгүй. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 06/1993 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 22 зорилт, 46 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 91 хувьтай хэрэгжсэн. Эрчимжүүлж ажиллах, удаашралттай байгаа арга хэмжээ байхгүй. Жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 07-ны өдөр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. | |
| **Зорилт 3.7** Тохижилтын ажлын үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бичил тохижилт бүхий амралт, спортын талбайг сэргээн засварлах ажлыг зохион байгуулна. /НЗДҮАХ 5.1.2.4/ | | - | Засварласан тоглоомын талбай, тоо | 38 тоглоомын талбайг засварласан. | 15 тоглоомын талбайг засварлана. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 2 дугаар хорооны 2 тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, 1, 2, 5, 12, 14 дүгээр хорооны 15 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайг засварлаж, орчны аюулгүй байдал, чанар, стандартыг хангуулах арга хэмжээ авч ажилласан. | 100% |
| 35 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, сандал, хогийн савнуудыг засварлаж, орчны аюулгүй байдлыг хангуулна. | 320.0 /ДТХО/ | Засварласан тоглоомын талбай, тоо | 38 тоглоомын талбайг засварласан. | 15 тоглоомын талбайг засварлана. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр хороо, 14, 15 дугаар байрны тоглоомын талбай, 2 дугаар хороо, 7, 8 дугаар байрны тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамжийн дагуу Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 1, 2, 5, 12, 14 дүгээр хорооны 15 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засварлах, орчны аюулгүй байдал, чанар, стандартыг хангуулах арга хэмжээ авч ажилласан. | |
| **Зорилт 3.8** Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулж органик бордоо үйлдвэрлэлтэд дэмжлэг үзүүлж ажиллана. /НЗДҮАХ 5.2.7/ | | - | Ажлын явц, хувь | Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлсэн. | Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлнэ | Хог ангилан ялгалтыг эрчимжүүлэх зорилгоор 4 удаагийн сургалт, өдөрлөг, "Хоггүй Хан-Уул дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх боломж шийдэл" хэлэлцүүлгийг зохион байгуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг эрчимжүүлсэн. | 85% |
| 36 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагад мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалт, хамруулсан аж ахуйн нэгжийн тоо | 1 сургалт арга хэмжээ зохион байгуулж, 5 аж ахуй нэгжийг хамруулсан. | 2-оос доошгүй сургалт арга хэмжээ зохион байгуулна. | Хог ангилан ялгалтыг эрчимжүүлэх зорилгоор 4 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, 120 сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагууд, хоол үйлдвэрлэгчдийг хамруулсан. "Хоггүй Хан-Уул дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх боломж шийдэл" хэлэцүүлгийг зохион байгуулж, хог тээврийн байгууллагууд, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, хоёрдогч түүхий эд авах цэг, томоохон үйлдвэрүүд, мэргэжлийн ТББ, олон улсын байгууллагын төлөөллүүдийг оролцуулж, санал шийдэл гаргасан. | 100% |
| 37 | Гэр хорооллын айл өрхүүдийн галлагаанаас гарсан үнсийг ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна. | - | Ажлын явц, хувь | Гэр хорооллын 1500 айл өрхөд үнс ангилан ялгах талаар зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. | Гэр хорооллын айл өрхүүдэд үнс ангилан ялгах талаар зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 2000 хүртэлх айл өрх үнсээ ангилж хэвшсэн байна. | Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр УБЗАА, "Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран үнсийг тусад нь ангилах зөвлөмж бүхий 500 ширхэг тараах материалыг гэр хорооллын айл өрхүүдэд тарааж мэдээлэл хүргэсэн. Дүүргийн хэмжээнд гэр | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооллын айл өрхийн 70 хувь нь үнсээ тусад нь ангилж хаяж байна. | |
| | **Зорилт 3.9** Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулж, хүн амын хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаална. /НЗДҮАХ 3.3.6/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Мал, амьтны халдварт өвчлөл буурна. | Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах зорилгоор дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Мал эмнэлгийн тасагтай хамтран мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж 2021 оны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж, зөрчил дутагдлыг арилгуулан 2022 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан. Нийт 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, Засаг даргын нөөцөөс 17.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. | 100% |
| 38 | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулна. | 50,0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:<br>• 2022 онд "Мал эмнэлгийн ажил гүйцэтгүүлэх" гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.<br>• Мал бүхий 12,13,14 дүгээр хорооны мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдварт өвчний дархлаажуулалтад давхардсан тоогоор 400371, бод, бог малын угаалга, туулгалтын ажилд 9676 толгой мал, амьтанг тус тус хамруулж, хяналт тавьж ажилласан.<br>• Гоц халдварт өвчний дархлаажуулалтад дүүргийн Засаг даргын 4 удаагийн захирамжаар 5 төрлийн өвчний дархлаажуулалтад 291279 толгой мал, амьтанг хамруулж, гоц халдварт өвчний гаралтгүй ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Дүүргийн хэмжээнд малын сэг зэм усталын ажлыг Мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төв, мал бүхий хороодын ажилтан албан хаагчидтай хамтран зохион байгуулж; 12,13,14 дүгээр хорооны 902 ширхэг мал, амьтны сэг зэмийг зориулалтын цэгт устгаж булшлан, 15950 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, малчин өрх, фермерүүдийн хашаа хорооны 325700м2 талбайд ариутгал хийж гүйцэтгэсэн.<br>Сүү бэлтгэн нийлүүлэгч 166 малчин, малтай өрх, аж ахуйн нэгжийн 600 саалийн үхэрт бруцеллёз өвчний тандалтын ажлыг зохион байгуулж, лабораторийн шинжилгээ болон технологийн ажилд хяналт тавьж ажилласан. | |
| **Зорилт 3.10** Хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /НЗДҮАХ 6.1.5/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 6 арга хэмжээ зохион байгуулсан. | Стандартын хэрэгжилт хангагдана. | Худалдаа үйлчилгээний газруудад хууль тогтоомж, стандартыг сурталчлах, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хотын өнгө үзэмж сайжруулах чиглэлээр Хотын стандарт, хяналтын газартай хамтран сургалт, уулзалт зохион байгуулсан. | 100% |
| 39 | Худалдаа үйлчилгээний байгууллагуудад стандартын хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллана. | 5,0 | Хяналт шалгалтын тоо | 2 удаа хяналт шалгалт хийсэн. | Стандарт, дүрэм журмын хэрэгжилт хангагдана. | Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, авто засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран цахим бүртгэлийн систем, худалдаа үйлчилгээний газарт тавигдах шаардлага стандартыг танилцуулах нийт 11 удаагийн сургалт уулзалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1074 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хотын стандартыг танилцуулах, иргэдэд амрах аялах таатай нөхцлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 6 удаагийн сургалт уулзалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 311 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, гарын авлага, танилцуулгаар хангаж, зөвлөн тусалж ажилласан.<br>Стандарт шаардлагуудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 5 удаа нийт давхардсан тоогоор 763 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан. | |
| 40 | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, орж ирсэн малыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. | 30,0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 арга хэмжээ зохион байгуулсан. | Стандарт, дүрэм журмын хэрэгжилт хангагдана. | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр 11 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 7.8 сая төгрөгийг үйл ажиллааны зардалд зарцуулсан. Үүнд:<br>• Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, хяналт тавих байнгын эргүүл жижүүрээр 2 ажилтанг ажиллуулан ажлын цаг ашиглалт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>• Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хариулгагүйгээр бэлчээсэн нийт давхардан тоогоор 6294 мал орж ирсэнээс 3740 малыг хориглосон бүсээс тууж гарган, 2554 малыг хашаалан 75 иргэнд Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газраас Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 3.75 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх чиглэлээр:<br>• Дүүргийн Засаг даргын 2022 оны 08/132 дугаар албан мэдэгдлийг 128 малчин болон мал бүхий иргэнд хүргүүлж, 12 дугаар хорооны мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд өвөлжсөн 30 тооны үхэрийг Төв аймгийн Батсүмбэр суманд нүүлгэн шилжүүсэн.<br>• Малчин мал бүхий иргэдэд нийслэлд мал аж ахуй эрхлэх журам, мал амьтны халдварт өвчний талаар холбогдох хууль, тогтоомжийг танилцуулж зөвлөгөө мэдээлэл өгөх уулзалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 256 иргэнг хамруулсан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүйгээр орж ирсэн гадны аймаг сумдын малчдаар Мал эмнэлгийн тасаг, хороо, Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран хяналт шалгалт зохион байгуулж, хугацаатай үүрэг даалгавар, албан мэдэгдэл өгч ажилласан. | |
| 41 | ТҮЦ, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн тоо, байршлыг тогтоож, хяналт тавьж ажиллана. | 30,0 | Байгуулсан цэг, дэмжин ажилласан иргэний тоо | - | 3-аас доошгүй худалдаа, явуулын хоол үйлдвэрлэлийн цэг байгуулж, 50-аас доошгүй иргэнийг дэмжин ажилласан байна. | Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр:<br>• "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн 2022 оны 5, 7 дугаар хурлаар ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэх байршил баталсан. Үүнд:<br>- Шинэ ургацын хүнсний ногоо гарсантай холбогдуулан үзэсгэлэн худалдаа зохион байгуулах 2 байршил батлаж, 18 газар тариалан эрхлэгчийг,<br>- Нисэхийн байрны буудал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчимд байрлаж ил задгай худалдаа эрхэлж буй иргэдийг "Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн"-д төвлөрүүлэн, байршил зааж, 24 иргэнийг тус тус дэмжин ажилласан. <br>• Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны "Ил задгай, гар дээрх худалдаа үйлчилгээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" удирдамжаар дүүргэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газар, хороодтой хамтарсан ажлын хэсэг 13 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 3 иргэнд тус бүр 20 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулан, зөвлөн тусалж ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 314 түргэн үйлчилгээний цэгийн судалгааг гаргаж, нийтийн эзэмшлийн зам талбай, авто болон явган хүний замыг хааж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчсөн 21 ТҮЦ-ийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. | |
| **Зорилт 3.11** Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчинг бүрдүүлнэ. /НЗДҮАХ 2.3.4.1/ | | - | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо | 336 хүүхэд хамрагдсан. | 450 хүүхэд хамруулна. | Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд 280 ширхэг гарын авлага, зөвлөмж, видео хичээлийг өрөнхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын 48 сургуульд хүргүүлж, JICA Олон улсын байгууллагаас ерөнхий боловсролын 26, 34, 75 дугаар сургуулийн "Дэмжлэгийн баг"-т 15.0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, сургуулийн 1, 2 дугаар давхрын хонгил, ариун цэврийн өрөөг тохижуулж, 75 дугаар сургуулийн дотоод орчинд тактель замыг байрлуулсан. Албан бус-Насан туршийн боловсролын төв тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэглэгдэхүүнтэй өрөөг ашиглалтад оруулсан.<br>Тэгш суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай ерөнхий боловсролын сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 10, налуу замтай 38 сургууль байна.<br>2022-2023 оны хичээлийн жилд 510 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. | |
| 42 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, ХБХ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | - | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан багш сурагчдын тоо | 2 удаагийн сургалтад 200 багш сурагчийг хамруулсан. | 4 удаагийн сургалтад 200 багш, 250 хүүхдийг хамруулна. | "Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд, сургалтын орчин, хамтын ажиллагаа" сэдэвт сургалтад 125 удирдах ажилтан, "Тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн онол практик" сургалтад 180 багш, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, ажиллах арга зүй" сургалтад 271 багш тус тус хамрагдсан.<br>Боловсролын хүрээлэн, ерөнхий боловсролын 63 дугаар сургууль хамтран нийслэлийн 25, 55, 63, 70 дугаар тусгай сургуулийн эцэг эх, сурагчдад хөдөлгөөн засал, хэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | заслын 5 удаагийн хичээлийг зохион байгуулсан. | |
| **ДӨРӨВ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 4.1** Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна. . /ДЗДҮАХ 2.2.2/ | | - | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо | 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 52726 иргэнийг хамруулсан. | 12 хүртэлх арга хэмжээ зохион байгуулж, 61000 иргэн хамруулна. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. 0-5, 6-17 насны иргэд өрхийн эрүүл мэндийн төвд, 18-30, 31-45, 46-60, 61-ээс дээш насны иргэд Эрүүл мэндийн төв, “Гэгээн ар үр” эмнэлэг, “Clinico health care” клиник, “ЭНЭҮТ”, “Санмедикал” эмнэлэг, Нэгдсэн эмнэлгүүдэд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдаж байна.<br>2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 0-5 насны 9637, 6-17 насны 19178, 18-30 насны 3406, 31-45 насны 4526, 46-60 насны 4303, 61-ээс дээш насны 3307, нийт 44357 иргэн эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдаад байна.<br>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд томуу, томуу төст өвчин, менингитийн дэгдэлт ихэссэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны А/152 дугаар захирамжаар бага насны хүүхдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 30,000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, төрийн болон төрийн бус өмчийн 38 сургуулийн 1-2 дугаар ангийн 12000 сурагч, 123 цэцэрлэгийн 18000 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэсэн. | |
| 43 | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн аяныг зохион байгуулна. | - | Үзлэг, нөлөөллийн арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо | ХДХВ/ДОХ/ БЗДХ-ын идэвхтэй эрт илрүүлэгт 5960 иргэнийг хамруулсан. | Халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 5500 иргэнийг хамруулж, эрт үед нь эмчилгээнд хамруулна. | Сүрьеэгийн эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, орон гэргүй болон эрсдэлт бүлгийн 200 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Дүүргийн хэмжээнд 141 сүрьеэ шинээр бүртгэгдэж, иргэдийг эмчилгээнд хамруулж байна. Сүрьэгийн эрт илрүүлэг 23%-тай байгаа нь өмнөх оныхоос 3 хувиар нэмэгдсэн байна. 2022 оны 10 дугаар сарын байдлаар ХДХВ/ДОХ/БЗДХ-ын кабинетын үзлэгт 9498 иргэн хамрагдсан нь өмнөх оны суурь түвшингээс 38%-иар илүү байгаа бөгөөд 101 өвчлөл бүртгэгдсэнийг 100% эмчилсэн. 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар товлолт вакцины бүрэн тунгийн хамралт 95% буюу өмнөх оны мөн үеэс 1 хувиар дээшилсэн үзүүлэлттэй байна. Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд "Сүрьеэгүй ирээдүй", "Эрүүл чийрэг эр хүн", "Эрүүл идэвхтэй амьдрал" "Харшлаас сэргийлцгээе", "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Эрүүл оюутан-Эерэг хандлага" зэрэг эрүүл мэндийн аяныг зохион байгуулсан. | 100% |
| 44 | Дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна. | - | Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдсан эсэх, | Эрүүл мэндийн төвийн дэргэд "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулсан. | Дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэлийн хувь | | | тогтоолын хүрээнд "Хан-Уул дүүргийн Нийгмийн Эрүүл мэндийн төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /ОНӨТҮГ/-ыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр тогтоолоор байгуулж, дүрмийг батлуулсан. | |
| **Зорилт 4.2** Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхыг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хорооны хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 3.1.2/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Дүүргийн алслагдсан 12,14,9,10,16 хороодод PRIUS-30 суудлын автомашин худалдан авсан. | Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ. | "Хорооны хөгжил" дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/122 дугаар захирамжаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төсвийг дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/134 дүгээр захирамжаар тус тус батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан. | 100% |
| 45 | Хороодын хөгжил дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ. | - | Төсөл арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | | Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Дэд хөтөлбөрийн төсвөөс дараах худалдан авалтуудыг хийж иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэж байна. Үүнд:<br>✓ 24 хороонд "Гэрэгэ" системийн КИОСК машин байршуулсан.<br>✓ Шинээр байгуулагдсан болон шинэ байранд орсон 11, 19, 23, 24 дүгээр хороодод иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх ухаалаг дэлгэц байршуулсан.<br>✓ Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хороодын үйл ажиллагаа, дүүргийн бүтээн байгуулалтыг иргэдэд сурталчлах постер, видео контент бэлтгэх ажлуудыг зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж нийт 112'216'000 төгрөгийг зарцуулсан. | |
| **Зорилт 4.3** Засаг захиргааны анхан шатны нэгж хорооноос иргэдэд хүргэж буй үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. /ДЗДҮАХ 3.2.2/ | | - | Цахимаар үзүүлэх үйлчилгээний нэр төрлийн тоо, үйлчилгээ үзүүлж байгаа хороодын тоо | Дүүргийн 21 хороонд улсын бүртгэлийн 8 төрлийн төрийн үйлчилгээг үзүүлж байна. | Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж хэвшсэн байна. | 2022 онд 24 хороодод улсын бүртгэлийн болон хөдөлмөр, халамжийн нийт 100 гаруй үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэж байна. | 100% |
| 46 | Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Цахимаар үзүүлэх үйлчилгээний нэр төрлийн тоо, үйлчилгээ үзүүлж байгаа хороодын тоо | Дүүргийн 21 хороонд улсын бүртгэлийн 8 төрлийн төрийн үйлчилгээг үзүүлж байна. | Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж хэвшсэн байна. | Дүүргийн 24 хороонд 2022 онд улсын бүртгэлийн 18 төрлийн лавлагаа, үйлчилгээг иргэдэд шинээр олгож эхэлсэн ба цахимаар иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн 39, лавлагаа 19, эд хөрөнгийн бүртгэлийн 9, лавлагаа 3 нэр төрөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр хүүхдийн мөнгөн тэтгэмж, цалинтай ээжийн тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж насны хишиг, "Эхийн алдар" одонтой эхийн тэтгэмж, асаргааны тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж гэх мэт нийгмийн халамжийн 69 нэр төрлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Мөн 24 хороонд КИОСК автомат машин байршуулснаар дээрх төрийн үйлчилгээний төдийгүй, бусад төрлийн нийт 115 нэр төрлийн татвар, төлбөр хураамжийн үйлчилгээг иргэд шуурхай авдаг болсон. | 100% |
| **Зорилт 4.4** Төрийн албан хаагчдыг чадваржуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна. /ДЗДҮАХ 3.3.1/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, сургалтад хамруулсан | Ажлын байран дээр чадваржуулах, хөгжүүлэх сургалтуудад давхардсан тоогоор 640 албан | 20-оос доошгүй сургалтад 200-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/129, А/527 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/18, А/87 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан хаагчдын тоо | хаагчийг хамруулсан. | | жагсаалтыг тус тус баталж хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулсан. 2022.04.25-ны өдрийн 04/644 дугаар албан бичгээр шинэчилсэн бүтцийн дагуу нийт төрийн захиргааны 34 албан тушаалын харьцуулалт, 2022.10.25-ны өдрийн А/527 дугаар захирамжийн дагуу албан тушаалын харьцуулалтыг дахин шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. | |
| 47 | Төрийн албан хаагчдыг чадваржуулах, сургаж хөгжүүлэх, дотоод болон гадаадын богино, дунд хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, сургалтад хамруулсан албан хаагчдын тоо | Ажлын байран дээр чадваржуулах, хөгжүүлэх сургалтуудад давхардсан тоогоор 640 албан хаагчийг хамруулсан. | 20-оос доошгүй сургалтад 200-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 7 ажил 90 хувийн хэрэгжилттэй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Удирдлагын академийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 4, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан бөгөөд Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуульд магистрын зэрэг горилсон гарагийн сургалтад суралцаж буй 4 албан хаагчид хичээлтэй гарагт цалинтай чөлөө олгон албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Нийслэлийн Хүний нөөцийн Хөгжлийн төвөөс зохион байгуулсан 20 төрлийн сургалтад давхардсан тоогоор 96 албан хаагч, "АЗ" гэрчилгээ олгох сургалтад 11 албан хаагчийг тус тус хамруулсан. Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" цахим | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад албан хаагчдыг тухай бүр идэвхтэй хамруулсан. Тайлант хугацаанд нийт 25 төрлийн сургалтад 122, цахимаар болон цаг үеийн шинжтэй бусад сургалтуудад 300 гаруй албан хаагчийг хамруулсан. | |
| 48 | ЗДТГ болон хороодын албан хаагчдын харилцан суралцах, зөвлөн туслах үйл ажиллагааны удирамж боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөө боловсруулж батлуулсан эсэх, хамруулсан албан хаагчдын тоо | - | 24-өөс доошгүй хороодод ажиллан 48-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Хан-Уул дүүргийн 24 хорооны ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй, дотоод ажлын эмх цэгц, мэргэшлийн ур чадварт ахиц гаргах зорилгоор Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дүүргийн хороодод зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын албан хаагчид хуваарийн дагуу 24 хороодын 50 албан хаагчдад өөрсдийн чиг үүргийн хүрээнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. | 100% |
| **Зорилт 4.5** Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. /ДЗДҮАХ 3.3.3/ | | - | Төлөвлөгөө батлуулсан эсэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөнд 11 ажлыг тусган, 95%-тай хэрэгжсэн. | Сахилга хариуцлагатай төрийн албыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100% хэрэгжүүлнэ. | Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа хандлагын нийтлэг журам"-ыг мөрдлөг болгон төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, сахилга хариуцлагыг сайжруулахад хяналт тавьсан. | 100% |
| 49 | Засгийн газрын 258 дугаар тогтоолын хүрээнд 2022 оны үйл ажиллагааны | - | Төлөвлөгөө батлуулсан эсэх, | Төлөвлөгөөнд 11 ажлыг тусган, | Сахилга хариуцлагатай төрийн албыг бүрдүүлж, | Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлнэ. | | төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95%-тай хэрэгжсэн. | төлөвлөгөөг 100% хэрэгжүүлнэ. | ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд 4 ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 90 хувьтай байна. Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн албаны соёл, дэг журмыг чангатгах, ажлын цаг ашиглалтыг сайжруулж хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд онцгой анхаарч, хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга болон хорооны Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгож дүүргийн Засаг даргын 2022 оны А/245 дугаар захирамжийг батлуулж, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/646 дугаартай албан бичгээр нийт 98 байгууллагад хүргүүлсэн.<br>Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны дарамт болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх хандлагыг төлөвшүүлэх сэдэвт сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимтэй хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад Засаг даргын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан болон хорооны Засаг дарга нар, нийт 51 албан тушаалтныг хамруулсан.Тайлант хугацаанд хариуцсан ажилдаа алдаа дутагдал гаргасан 6 албан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | . | хаагчид сахилгын арга хэмжээ ногдуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын захирамжаар 4 албан тушаалтанд албан тушаалаас бууруулах, 1 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 1 албан хаагчид 1 сарын цалингийн 20 хувиар бууруулах сахилгын арга хэмжээ тус тус авсан. | |
| 50 | 5.1.2 "Ёс зүйн зөвлөл"-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөө батлуулсан эсэх, хэрэгжилтийн хувь | 2021 оны А/34 дүгээр тушаалаар зөвлөлийн ажиллах журмыг баталсан. | Ёс зүйтэй төрийн албыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100% хэрэгжүүлнэ. | Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажил 85 хувийн хэрэгжилттэй.<br>Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх талаар нийт албан хаагчдад анхааруулж, хяналт тавьсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 7 өргөдөл ирүүлснээс 5 албан хаагчтай холбоотой асуудлыг байгууллагын Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор дээрх 5 албан хаагчид сануулах хариуцлага хүлээлгэсэн бөгөөд тус дүүргийн 10 дугаар хорооны нийгмийн ажилтанд ЗДТГ-ын даргын 2022.04.11-ний өдрийн Б/55 тушаалаар албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл, 4 дүгээр хорооны хэсгийн ахлагч н.Сэржмаад урамшууллын 20 хувийг хасах шийдвэр гаргаж, 2022.10.20-ны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цалингаас суутган албан хаагчдад тус тус хариуцлага тооцсон. | |
| **Зорилт 4.6** Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороог ажлын албатай болгон санхүүгийн хувьд бэхжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 3.3.4/ | | - | Бүтэц орон тоог шинэчилсэн эсэх | - | Бүтэц орон тоог шинэчилж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ. | Нийслэлийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 68 дугаар тогтоолоор дүүргийн зарим хорооны нутаг дэвсгэр, хилийн заагийг шинэчлэн, 5 хороог шинээр байгуулж, нийт 24 хороо үйл ажиллагаа явуулж байна. | 80% |
| 51 | Хороодыг ажлын албатай болгох хүрээнд бүтэц зохион байгуулалтыг шинэчилж, шаардлагатай бэлтгэл ажлыг хангана. | - | Бүтэц орон тоог шинэчилсэн эсэх, ажлын явц | - | Бүтэц орон тоог шинэчилж, төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 68 дугаар тогтоолоор дүүргийн зарим хорооны нутаг дэвсгэр, хилийн заагийг шинэчлэн, 5 хороог шинээр байгуулж, нийт 24 хороо үйл ажиллагаа явуулж байна. Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар 25 хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай хангамжийн зардал болох сар тутмын 500,0000 төгрөг буюу нийт хороодын жилийн зардалд 156,931,200 төгрөгийн төсөв батлагдаж, зардлыг хороодод тогтмол олгож байна. | 100% |
| 52 | 15, 21 дүгээр хорооны цогцолбор барилгын ажлыг дуусган, Яармагийн шинээр байгуулагдсан хороонд хорооны барилга худалдан авч, 16 дугаар хорооны цогцолбор барилгын ажлыг эхлүүлнэ. | 7,092.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | 2 хороонд байр худалдан авсан. | 3 хороог байртай болгож, 1 хорооны барилгын ажлыг эхлүүлнэ. | Хан-Уул дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:<br>-21 дүгээр хороонд шинээр баригдаж буй хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дотор засал, гадна фасадны ажил хийгдэж | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаа бөгөөд 12 дугаар сарын 25-нд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>-15 дугаар хороонд шинээр баригдах хороо өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв батлагдсан. Барилга угсралтын суурийн ажил эхэлсэн. Ажлын явц 10%.<br>-16 дугаар хороонд шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгч шалгарсан, зураг төсвийн шатанд байна. | |
| **Зорилт 4.7** Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн "Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.5.6/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Төсөл хэрэгжээгүй | Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ. | "Архигүй орчин" дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/122 дугаар захирамжаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төсвийг дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/134 дүгээр захирамжаар тус тус батлуулан хэрэгжилтийг хангуулсан. | 100% |
| 53 | "Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй | Төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулсан байна. | "Архигүй орчин" дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/122 дугаар захирамжаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төсвийг дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А/134 дүгээр захирамжаар тус тус батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Архигүй орчин" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хуралдуулж Цагдаагийн газрын "Шинээр томилогдсон алба хаагчдыг техник хэрэгсэлээр хангах төсөл", 6 дугаар хорооны "Архигүй орчин" төсөл, Албан бус-Насан туршийн боловсролын төвийн "Урам" архины хамааралтай иргэдийн зан үйлийг засах төслүүдийг тус тус хэлэлцүүлэн дэмжүүлж, 06 дугаар сарын 02-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулгыг бэлтгэн дэмжүүлсэн. Хурлаар дээрх 3 төсөл арга хэмжээ дэмжигдсэнээс Цагдаагийн газрын "Шинээр томилогдсон алба хаагчдыг техник хэрэгсэлээр хангах төсөл", 6 дугаар хорооны "Архигүй орчин" төслүүд амжилттай хэрэгжиж 33,159,000 төгрөгийг зарцуулсан. | |
| **Зорилт 4.8** "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлыг судлан үе шаттайгаар эхлүүлнэ. /ДЗДҮАХ 2.1.1/ | | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | | Стандарт нэвтрүүлэх ажлыг судалж, удирдлагад танилцуулах | "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх талаар судлан, мэдээлэл цуглуулсан. | 30% |
| 54 | "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлыг судлан үе шаттайгаар эхлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | - | Стандарт нэвтрүүлэх ажлыг судалж, нэвтрүүлнэ. | "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх талаар "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-ын Гүйцэтгэх захирал Т.Мөнгөнбөгжтэй 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр уулзан санал солилцож арга зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан. ISO стандарт нэвтрүүлэх ажлын 2023 оноос үе шаттайгаар нэвтрүүлэхээр төсвийн санал хүргүүлсэн. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.9** Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцыг авто замд барих ажлыг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 5.3.3/ | | - | Ашиглалтад орсон нүхэн гарцны тоо, ажлын явц, хувь | 1 нүхэн гарцын гэрээ байгуулагдсан. | 100%<br>1 гарц ашиглалтад орж, 1 гарцын ажил эхэлсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд он дамжин хэрэгжих "Наадамчдын авто замд явган хүний нүхэн гарц барих" /4 дүгээр хороо, Хүннү молл худалдааны төвийн урд/ ажлын гүйцэтгэгчээр "Туулын гүүр далай" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нүхэн гарцын дотор засал, гадна шилэн хийцлэл, тохижилтын ажил хийгдэж байна. 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор ашиглалтад оруулна. | 100% |
| 55 | Наадамчдын авто зам дагуу "Хүннү молл" худалдааны төвийн урд 1 нүхэн гарц ашиглалтад оруулж, тус замд дахин 1 гарцын байгууламжийн ажлыг эхлүүлнэ. | 1,798.6 /ДТХО/ | Ашиглалтад орсон нүхэн гарцын тоо, ажлын явц, хувь | 1 нүхэн гарцын гэрээ байгуулагдсан. | 100%<br>1 гарц ашиглалтад орж, 1 гарцын ажил эхэлсэн байна. | "Наадамчдын авто замд явган хүний нүхэн гарц барих" /4 дүгээр хороо, Хүннү молл худалдааны төвийн урд/ нүхэн гарцын дотор засал, гадна шилэн хийцлэл, тохижилтын ажил хийгдэж байна. 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор ашиглалтад оруулна. "Тусгай замын автобус LRT төсөл" хэрэгжихтэй холбоотойгоор ЧӨЧ болон Наадамчдын авто зам дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх чиглэл өгсөн тул "Наадамчдын авто замд явган хүний гарцын байгууламж барих /8 дугаар хороо/" ажлыг дүүргийн ИТХ-ийн 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 20 дугаар тогтоолоор 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас хассан. | 100% |
| **Зорилт 4.10** Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана.<br>/ДЗДҮАХ 5.3.7/ | | - | Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байршлын тоо | Алслагдсан хороодын цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төсөв хийгдсэн. | 13, 14 дүгээр хороонд 7 байршилд цахилгааны хүчдэл сайжруулсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 2б, 14 дүгээр хорооны 1, 2, 4, 5, 7 дугаар хэсгийн 374 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулсан. Дүүргийн 12 дугаар хороонд цахилгааны хүчдэлийн уналт сайжруулах 1 зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ хэрэгжсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | 13, 14 дүгээр хороонд хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй өрхийг цахилгаан шугам, сүлжээнд холбож, алслагдсан хороодын цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгүүлж дуусгана. | 1,730.0 ДТХО | Цахилгаан эрчим хүчээр хангагдсан байршлын тоо | Алслагдсан хороодын цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төсөв хийгдсэн. | 13, 14 дүгээр хороонд 7 байршилд цахилгааны хүчдэл сайжруулсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар 13 дугаар хорооны 2б хэсгийн 21 өрх, 14 дүгээр хорооны 1, 5 дугаар хэсгийн 223 айл өрхийн цахилгааны хүчдэлийг сайжруулах ажил хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14 дүгээр хорооны 1, 2, 4, 7 дугаар хэсгийн нийт 151 айл өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороо Хайрхан хэсгийн Сонгино 27 дугаар гудамжны айл өрхийн хүчдэлийн уналтыг сайжруулах зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил хийгдсэн | 100% |
| **Зорилт 4.11** Хог хаягдлын тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын авто машины парк шинэчлэлтийг үе шаттай хийж, хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 5.4.2/ | | - | Нийлүүлэгдсэн авто машины тоо, нийлүүлэгдэх ажлын явц, хувь | 2021 онд 4 авто машин нийлүүлэгдсэн. 6 авто машин нийлүүлэгдэх шатанд байна. | 14-өөс доошгүй авто машин нийлүүлэгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 8 автомашинаар парк шинэчлэлт хийсэн. | 70% |
| 57 | Хог тээврийн болон зам цэвэрлэгээ, усалгааны авто машин худалдан авна. | 5,440.0 /ДТХО/ | Нийлүүлэгдсэн авто машины тоо, нийлүүлэгдэх ажлын явц, хувь | 2021 онд 4 авто машин нийлүүлэгдсэн. 6 авто машин нийлүүлэгдэх шатанд байна. | 14-өөс доошгүй авто машин нийлүүлэгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр нийт 26 хог тээврийн болон зам цэвэрлэгээ усалгааны авто машин худалдан авхаар төлөвлөсөнөөс 8 авто машинаар парк шинэчлэлт хийсэн. Үүнд: Хьюндай HD-72 маркийн 6 м3 хог шахаж ачих зориулалтын 6 автомашин, зам цэвэрлэгээ усалгааны хосолмол үйлдэлтэй 2 авто машинаар парк шинэчлэлт хийсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр хог тээврийн авто машин худалдан авах БАГЦ-2 буюу | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хьюндай HD-78 маркийн 6 м3-ийн 7 авто машин, Хьюндай HD-170 маркийн 14. м3-ийн 4 авто машин буюу нийт 11 ширхэг хог шахаж ачих зориулалтын авто машин үйлдвэрлэгдэж бэлэн болсон бөгөөд тээвэрлэлтийн шатанд байна. 2022 оны 12 дугаар сарын 25-нд нийлүүлэгдэнэ.<br>Хог тээврийн 7 авто машин худалдан авах /БАГЦ-1/ ажлыг дүүргийн ИТХ-ийн 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас хассан. | |
| 58 | Зам цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин, шинээр тавигдсан авто замуудын арчлалт хамгаалалтыг ээнжүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Зам цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч, шинээр тавигдсан авто замуудыг хариуцсан байгууллагуудад хуваарилсан байна. | Дүүргийн хог тээвэрлэлт, зам цэвэрлэгээ хариуцсан 4 ОНӨААТҮГ, 2 аж ахуйн нэгж, байгууллагын ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 123,952.65 тонн энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хүргэж, 46.385 тонн хог хаягдлыг дахин боловсруулж ашигласан байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/556 дугаар захирамжаар 5, 6, 9, 10, 11, 12, 13, 16, 18, 19, 20, 23 дугаар хорооны нийт 187,827 м.кв талбай бүхий 46 замын цэвэрлэгээ үйлчилгээг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т нэмэлтээр хариуцуулж, хяналт тавьж ажиллаж байна. | 100% |
| **Зорилт 4.12** Засаг даргаас бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дүүрэг хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэх, хяналт | | - | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хувь | ЗДҮАХ-ийн 2021 оны хэрэгжилт 90.4% байна. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 108 зорилт, 151 арга хэмжээний биелэлтийг нэгтгэж 12 дугаар сарын 5-ны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавих, шаардлагатай бүх төрлийн мэдээллийг боловсруулан дүгнэлт, санал бэлтгэх ажлыг зохион байгуулж Засаг даргыг мэдээллээр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | өдрийн дотор дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барина. | |
| 59 | Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулж, хэрэгжилт үр дүнг тайлагнана. | ҮА-ны зард-лаар | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хувь | ЗДҮАХ-ийн 2021 оны хэрэгжилт 90.4% байна. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 108 зорилт, 151 арга хэмжээний биелэлт 91 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 60 | Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ байгуулж, дүгнэсэн эсэх | 27 байгууллагатай гэрээ байгуулж, дүгнэсэн. | Гэрээ байгуулж, дүгнэсэн байна. | Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний биелэлтийг 26 дэргэдэх хэлтэс, албаас авч, нэгтгэн, боловсруулж байна. | 70% |
| **Зорилт 4.13** Төрийн байгууллагуудад үйл ажиллагаагаа хэвийн явуулах, иргэдэд саадгүй үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. | | - | Ажлын явц, хувь | Эко ахмадын сувилал ААТҮГ-т шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | Төрийн байгууллагуудын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна. | Хан-Уул дүүргийн хэмжээнд үйлчилгээний жишиг нийцсэн өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих 6 төсөл арга хэмжээ хэрэгжихээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:<br>-14 дүгээр хороонд өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажил бүрэн дууссан.<br>-21 дүгээр хороонд шинээр баригдаж буй хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дотор засал, гадна фасадны ажил хийгдэж байна. Ажлын явц 80%. | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -15 дугаар хороонд шинээр баригдах хороо өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв батлагдсан. Барилга угсралтын суурийн ажил эхэлсэн. Ажлын явц 10%.<br>-8 дугаар хороонд шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгч шалгарсан, зураг төсвийн шатанд байна.<br>-16 дугаар хороонд шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгч шалгарсан, зураг төсвийн шатанд байна.<br>-24 дүгээр хороонд шинээр баригдах хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын газрын асуудал шийдвэрлэгдэх шатанд байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19 дүгээр хороонд өрхийн эмнэлгийн барилга худалдан авч, эмнэлгийн стандартад нийцсэн засвар тохижилтыг хийж ашиглалтад оруулсан. | |
| 61 | Хороод болон Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 685.0 /ДТХО/ | Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн эсэх | - | Тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. | Дүүргийн Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлын зохион байгуулж шаардлагатай 5 нэр төрлийн 71 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Мөн дүүргийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай "Зөөврийн дизель насос"-ыг худалдан авч нийлүүлсэн. Хороодын албан хэрэгцээнд тавилга, эд хогшил худалдан авах ажлын тендерийг 2022.02.18-ны өдөр зарласан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас Монгол улсын Засгийн Газрын 2021 оны 388 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тогтоолын дагуу тендерийг хүчингүй болгосон. | |
| 62 | Шинэ Нэгдсэн эмнэлэг барихтай холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн гадна барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбайн буулгалтын ажлыг гүйцэтгүүлнэ. | 185.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Буулгалтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих "Нэгдсэн эмнэлгийн гадна барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбайн буулгалт"-ын ажлын гүйцэтгэгчээр "Юу зэт эрдэнэ" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нэгдсэн эмнэлгийн хуучин 7 объект буулгахаас 5 объектийг буулгасан. Үлдсэн 2 объект нь шинээр баригдах 200 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын гадна шугам сүлжээний ажил 2023 оны хавар хийгдсэний дараа буулгах шаардлагатай болсон тул он дамжин хэрэгжихээр болсон. Ажлын явц 70%. | 100% |
| 63 | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг буулгаж, шинээр барина. | 600.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Барилгыг шинэчилсэн байна. | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг буулгаж, шинээр барих төсөл арга хэмжээний ажлын даалгавар боловсруулж, худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгч, 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр тендер зарлан 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нээлт хийсэн боловч аж ахуй нэгж материал ирүүлээгүй тендер хүчингүй болсон.<br>Дүүргийн төсвийн орлогын биелэлт тасарч байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлэх боломжгүй болох эрсдэл үүсэж байгаатай холбогдуулан Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоох шийдвэр гарсан. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | Эрүүл мэндийн төв, Усан спорт сургалтын төв, Замын цагдаагийн хэлтсийн барилгын засвар, шинэчлэлт, Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах ангийн авто машины гараашийн өргөтгөлийн ажлыг гүйцэтгүүлнэ. | 1,390.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Барилгын засвар, шинэчлэлт, өргөтгөлийн ажил хийгдсэн байна. | "Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар" ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, гүйцэтгэгчээр "Рокгранд" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 70 хувьтай.<br>"Усан спорт сургалтын төвийн дээвэр, фасад засвар"-ын ажил хийгдэж дууссан.<br>"Замын цагдаагийн хэлтсийн барилгын дулаалга, фасад засвар" ажил хийгдэж дууссан.<br>"Гал унтраах ангийн автомашины гараашийн өргөтгөл" ажлын тендерийн 8 удаа зарласан. Тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. | 70% |
| **Зорилт 4.14** Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлнэ. | | ҮА-ны зардлаар | Төсөв хугацаанд нь батлуулсан эсэх | 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг ДИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор батлуулсан. | Жил бүр хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийж, төсвийг батлуулсан байна. | Улс, нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг дэргэдэх хэлтэс, алба, хороодоос авч нэгтгэн ирүүлсэн хавсралтын дагуу боловсруулж Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дугаар албан бичиг, Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06/295 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус уламжилсан. Дүүргийн 2023 оны төсөвт тусгуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын саналыг хороод болон дэргэдэх хэлтэс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албадаас авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд нь батлуулсан. | |
| 65 | Дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг, бодлогын баримт бичгүүд болон бусад эх үүсвэрийн төсвийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж батлуулна. | УА-ны зардлаар | Орон нутгийн төсвийг хуулийн хугацаанд батлуулсан эсэх. | 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг ДИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор батлуулсан. | 2023 оны төсвийн төлөвлөлтийг хийж, 2022.12.20-ны өдрийн дотор ДИТХ-ын тогтоолоор батлуулсан байна. | Улс, нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг дэргэдэх хэлтэс, алба, хороодоос авч нэгтгэн ирүүлсэн хавсралтын дагуу боловсруулж Монгол улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дугаар албан бичиг, Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06/295 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус уламжилсан. Дүүргийн 2023 оны төсөвт тусгуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын саналыг хороод болон дэргэдэх хэлтэс албадаас авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд нь батлуулсан. | 100% |
| 66 | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн ажил болон дүүргийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, нэгжийн дарга болон байгууллагын даргаар батлуулан Худалдан авах ажиллагааны албанд | УА-ны зардлаар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Төсөл, арга хэмжээнүүдийн тендер зарлахад шаардагдах баримт бичгүүдийг ХУДХААА-нд шуурхай хүлээлгэн өгсөн байна. | Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 42 төсөл, арга хэмжээний 77 багц ажлын худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирснийг Худалдан авах ажиллагааны албанд бүрэн хүлээлгэн өгсөн.<br>Явцаар нь авч үзвэл:<br>• гэрээ байгуулсан /41/,<br>• гэрээ байгуулах шатанд /26/,<br>• үнэлгээ хийгдэж байгаа /2/, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын зураг төсөв болон холбогдох бусад материалын хамт шилжүүлнэ. | | | | | • тендер зарлах шатанд /8/ багц ажил байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 42, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 2, нийт 44 төсөл, арга хэмжээг 2022 онд шинээр хэрэгжүүлэхээс 42 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн.<br>Явцаар нь авч үзвэл:<br>• Хэрэгжиж дууссан /19/<br>• Гэрээ байгуулагдсан /15/<br>• Тендер зарласан ажлууд /3/<br>• Тендер зарлах шатанд /5/<br>Газрын асуудал шийдвэрлэх шатанд /1/<br>Ажлын даалгавар хүлээгдэж байгаа /1/ төсөл арга хэмжээ байна. | |
| **Зорилт 4.15** Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 1.1.3/ | | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, % | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 85028 ширхэг мод, бут, сөөг тарьж, 16944 м.кв талбайг зүлэгжүүлсэн. | мод тарих, үржүүлгийн газар байгуулах, гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээ хийж, цэцгийн мандал байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. | Дэд хөтөлбөрийн хүрээнд 260361 ширхэг мод, бут, сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 267,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах, 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн. | 100% |
| 67 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Бүх нийтээр мод тарих" үндэсний өдөр арга хэмжээг зохион байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана. | 40.0 /ДТХО/ | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 85028 ширхэг мод, бут, сөөг тарьсан. | "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" арга хэмжээг 2 удаа зохион байгуулна. | "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулж, 2022 онд дүүргийн хэмжээнд 260,361 ширхэг мод, бут, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сөөг тарьж, 46341,2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлсэн. | |
| 68 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний бэлтгэл ажлын хүрээнд мод үржүүлгийн газар байгуулах ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулж, мод үржүүлгийн газар байгуулах ажлыг эхлүүлнэ. | 1,050.0 /ДТХО/ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Дүүргийн харьяанд мод үржүүлгийн газар байхгүй. | Мод үржүүлгийн газрын зураг, төсөв, ТЭЗҮ-г боловсруулж, үржүүлгийн ажлыг эхлүүлсэн байна. | Дүүргийн төсвийн 19.0 сая төгрөгийн хөрөнгөөр Айцын аманд ойжуулалт, ойн зурвас байгуулах талбайн зураг төсөл магадлал хийгдэх шатанд, 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр 13 дугаар хороонд мод үржүүлгийн газар байгуулах ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил ТЭЗҮ боловсруулагдсан, эскиз зураг боловсруулах шатанд хэрэгжиж байна. | 80% |
| 69 | Цэцгийн үрсэлгээ хийх, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэцгийн мандал байгуулж, хотын өнгө, үзэмжийг нэмэгдүүлэх "Сая сарнай" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 100.0 /ДТХО/ | Үрслүүлсэн цэцэг, тоо | 388,882 ширхэг цэцгийг үрслүүлж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 32 байршилд цэцгийн мандал байгуулсан. | 200,000 ширхэгээс доошгүй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлнэ. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжийн дагуу 10 төрлийн гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд 267519 цэцэг тарьж цэцгийн мандал байгуулах ажлыг хэрэгжүүлж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна.<br>Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ Чингисийн өргөн чөлөөний авто замын 5 бульварт нийт 1800 ширхэг гоёл, чимэглэлийн байцаан цэцэг тарьсан. | 100% |
| **Зорилт 4.16** Дүүргийн гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлнэ. /ДЗДҮАХ 5.1.4/ | | - | Хяналт тавьсан төсөл арга хэмжээ, тоо | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 47 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 64 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана. | Дүүргийн төсвөөр хэрэгжиж буй 78 төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг хангуулах арга хэмжээ авч ажилласан. | 100% |
| 70 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлд тогтмол | - | Хяналт тавьсан төсөл арга хэмжээ, тоо | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 47 төсөл арга | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 64 төсөл арга хэмжээний | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/541 дүгээр захирамжаар байгуулагдсан Техник хяналтын комисс дүүргийн төсвөөр хэрэгжиж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлж ажиллана. | | | хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. | ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана. | буй 78 төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг хангуулах арга хэмжээ авч ажилласан. | |
| 71 | Эвдрэлтэй авто замыг нөхөж, засварлаж, зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. | 2,390.0 /ДТХО/ | Засварласан зам, талбай, м.кв | Эвдрэлтэй 8027 м.кв талбай авто замыг нөхсөн. | Эвдрэлтэй 7000 м.кв-аас доошгүй авто замыг нөхнө. | Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ дүүргийн 21 дүгээр хороонд 3800 м.кв талбай /урт 190 метр, өргөн 20 метр/-д асфальтон бетонон хучилттай авто зам, зогсоол, 9 дүгээр хороонд Нисэх шинэ эцэст 1040 м.кв талбайд нийтийн тээврийн зогсоол, гарааш чөлөөлсөн талбайг тохижуулах ажлын хүрээнд 1, 2 дугаар хорооны 4 байршилд 1185 м.кв талбайд авто зогсоол шинээр байгуулж, ашиглалтад оруулсан.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 11, 15, 17, 18, 19, 20, 23 дугаар хорооны нутаг дэвсгэр эвдрэлтэй авто замын 1468 м.кв талбайд нөхөөс хийх, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороонд ус их хэмжээгээр тогтдог, зорчиход хүндрэлтэй гэр хорооллын 48, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 5, 6, 7, 8, 10 дугаар хорооны 10, нийт 58 гудамж талбайг хусаж тэгшлэх, зохист найрлагатай дайргаар засварласан.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ 1, 2, 3, 4, 10, 11, 12, 14, 15 дугаар хороодын эвдрэл ихтэй авто замын судалгааг гаргаж, 139 байршилд 7000 м.кв асфальтбетон нөхөөсийн ажлыг гүйцэтгэж, шинээр 1170.2 м.кв авто замын хэвтээ тэмдэглэгээ, 71 байршилд авто замын тэмдэг шинээр байршуулах, Наадамчдын зам, Чингисийн өргөн чөлөө, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажилчдын гудамж дагуух 694,5 урт метр хайсыг засварласан. | |
| 72 | Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллана. | 714.4 /ДТХО/ | Засвар үйлчилгээг хариуцах гэрэлтүүлэг, тоо | Орон сууц, гэр хорооллын 6251 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. | Орон сууц, гэр хорооллын 6251 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.<br>Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний хүрээнд 4420 метр кабель шугам, 1740 ширхэг гэрэлтүүлэг, 446 ширхэг гэрэлтүүлгийн шон, 211 ширхэг цахилгааны самбарын хайрцагт засвар, 68 ширхэг гэрэлтүүлгийн шон будах ажил үйлчилгээ хийсэн байна. Мөн 120 мянгатын цэцэрлэгт хүрээлэнгийн нэмэлт гэрэлтүүлэг хийж талбайн хэсгийг бүрэн гэрэлтүүлсэн, 19-ийн үйлчилгээний төвийн авто зам болон арьс ширний гудамжны гэрэлтүүлгүүд нь бүдэг натри гэрэлтүүлэгч байсныг 100вт-ийн лед гэрлээр бүрэн сольж шинэчилсэн. Асалт 96 хувь | 100% |
| 73 | Төсвийн хөрөнгөөр суурилуулсан камерын засвар, үйлчилгээг сайжруулж, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | 690.0 /ДТХО/ | Засвар үйлчилгээг хариуцах камер, тоо | 991 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. | 991 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/57 дугаар захирамжаар Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-т төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан бүх төрлийн камерын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцуулсан. Тус дүүргийн нутаг дэвсгэрт 129 байршилд нийт 1061 хяналтын камер байршуулснаас энэ оны хагас жилийн байдлаар 171 камерын ашиглалтын хугацаа дуусаж, солих шаардлагатай болсон бөгөөд 39 хяналтын камерт ээлжит засвар үйлчилгээ хийгдэж, нийт 890 хяналтын камер бүрэн ажиллаж байна.Тус ажлын хүрээнд 1, 5, 7, 8, 13, 14, 15, 18, 19, 20 дугаар хороодод байрлах цэцэрлэг, сургуулийн ойр орчмын зам гарц | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээр нийтийн эзэмшлийн гудамж талбай руу харсан 64 ширхэг гадна, 1, 8, 9, 10 дугаар хороодын байранд 28 ширхэг хяналтын камер шинээр суурилуулсан. | |
| **Зорилт 4.17** Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ. /ДЗДҮАХ 5.3.5/ | | 200.0 /ДТХО/ | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | 16944 м.кв талбайг зүлэгжүүлсэн. | 10000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ. | Дүүргийн хэмжээнд 1, 2, 3, 4, 8, 12, 15, 16, 19, 20 дугаар хороонд 37 байршилд 29,625.6 м.кв талбайд шинээр явган хүний зам тавьж, 3,213.9 м.кв явган замыг засварлаж, 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан. | 100% |
| 74 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь сул шороо хөрс бүхий талбайг зүлэгжүүлж тоосжилтыг бууруулна. | 200.0 /ДТХО/ | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | 16944 м.кв талбайг зүлэгжүүлсэн. | 10000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ. | Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтаар болон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан. | 100% |
| 75 | Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул-2022" аяныг зохион байгуулна. | - | Ажлын явц, хувь | Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын парк шинэчлэлтийг хийж, хог тээврийн 2 байгууллагыг шинээр байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлсэн. | Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын парк шинэчлэлтийг хийсэн байна. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/56 дугаар захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2022" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 280 сууц өмчлөгчдийн холбоодын 24920 хүн оролцож, 863,876 м.кв талбайгаас 1227,2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна. | 100% |
| 76 | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлж бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулна. | 40000.0 /ЗДТГ/ | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 8 удаа их цэвэрлэгээ зохион байгуулсан. | 8-аас доошгүй удаагийн "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-г зохион байгуулсан байна. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/56 дугаар захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2022" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэвэрлэгээг зохион байгуулж нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 280 сууц өмчлөгчдийн холбоодын 24920 хүн оролцож, 863,876 м.кв талбайгаас 1227,2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна. | |
| **Зорилт 4.18** Аж ахуйн нэгж байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 5.6.1/ | | - | Зохион байгуулсан ажил арга хэмжээ | - | "Ус ашиглах зөвшөөрөл", "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл" олгох гэрээ байгуулж, хяналт тавьж, усны мэдээллийн санд бүртгэнэ. | Холбогдох шатны байгууллагуудын дүгнэлтийг үндэслэж 6 аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах зөвшөөрөл, 6 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, 1 байгууллагын хаягдал усны цэг тогтоосон. | 100% |
| 77 | Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл", "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл" олгох гэрээ байгуулж, хяналт тавьж, усны мэдээллийн санд бүртгэнэ. | - | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | 5 аж ахуй нэгж, байгууллагад зөвшөөрөл олгосон. | 6-аас доошгүй аж ахуй нэгжид ус ашиглах, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл олгож, мэдээллийн санд бүртгэнэ. | Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 6 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгож, усны мэдээллийн санд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна. Зөвшөөрөл олгосон байгууллагуудын мэдээллийг дүүргийн Татварын албанд хүргүүлэн татвар төлөгчөөр бүртгүүлсэн. | 100% |
| 78 | Нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслэн усны нөөц ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулж, усны мэдээллийн санд бүртгэнэ. | - | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | 3 аж ахуй нэгж, байгууллагад зөвшөөрөл олгосон. | Дүгнэлтийг үндэслэн 3-аас доошгүй ус ашиглагчид зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан байна. | Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 6 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгож, усны мэдээллийн санд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна. Зөвшөөрөл олгосон байгууллагуудын мэдээллийг дүүргийн Татварын албанд хүргүүлэн татвар төлөгчөөр бүртгүүлсэн. | 100% |
| 79 | Туул голын сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл | - | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | 2 аж ахуй нэгж, байгууллагад зөвшөөрөл олгосон. | Дүгнэлтийг үндэслэн 3-аас доошгүй ус ашиглагчид хаягдал ус хаях, зайлуулах | Туул голын сав газрын захиргаанаас ирүүлсэн "Хаягдал ус хаях" дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн дагуу 5 аж ахуй нэгж, 1 иргэнд ус хаях зөвшөөрөл шинээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | олгож, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана. | | | | зөвшөөрөл олгосон байна. | олгож, гэрээ байгуулж, 1 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг сунгасан. Усны газрын дүгнэлтийг үндэслэн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ТӨХК-д хаягдал усны цэг тогтоож, хяналт тавин ажиллаж байна. Зөвшөөрөл олгосон байгууллагуудын мэдээллийг дүүргийн Татварын албанд хүргүүлэн татвар төлөгчөөр бүртгүүлсэн. | |
| **Зорилт 4.19** Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 5.1.6/ | | - | Зохион байгуулсан шалгалтын тоо | 12 удаа хяналт шалгалт хийсэн. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 10-аас доошгүй удаагийн хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулна. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/137, А/177 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн тогтмол хяналт тавьж, ажиллаж байна. | 100% |
| 80 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | - | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хэрэгжилтийн хувь | 12 удаа хяналт шалгалт хийсэн. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 10-аас доошгүй удаагийн хяналт шалгалт явуулна. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, дүүргийн Засаг даргын 2022 оны А/77, А/146 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч **14** аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан бөгөөд 4 аж ахуйн нэгж хангалттай, 10 аж ахуйн нэгж, байгууллага хангалтгүй үнэлгээ авсан. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөршөөрөл нь цуцлагдсан 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоосон. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/137, А/177 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарсан шалгалт хийж, усны зөвшөөрөлгүй 5 аж ахуй нэгж, хог тээврийн гэрээ байгуулаагүй 4 аж ахуй нэгжийн зөрчлийг арилгуулсан. Аж ахуй нэгжүүдийн 2022 оны байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 35,3 га газарт техникийн нөхөн сэргээлт, 12,5 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. | |
| **Зорилт 4.20** Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна. /ДЗДҮАХ 2.1.4/ | | - | Хамрагдсан тамирчдын тоо, хэрэгжилтийн хувь | Спортын 8 төрөлд 775 тамирчин оролцуулсан. | Спортын 8 төрөлд 2000-аас доошгүй тамирчин оролцуулна. | Өсвөр үе, залуучуудын шигшээ багийн 29 тамирчин дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд жүдо, самбо, даамны төрөлд алт 5, мөнгө 2, хүрэл 1, Олон улсын хүүхдийн наадам болон чөлөөт бөхийн олон улсын тэмцээнд мөнгө 1, хүрэл 2, Азийн аварга шалгаруулах тэмцээнд жүдо, даамны төрөлд алт 5, мөнгө 2, хүрэл 1 нийт 19 медаль хүртсэн. Улсын чанартай спортын уралдаан тэмцээнд спортын 8 төрлөөр 50 удаагийн тэмцээнд давхардсан тоогоор 2356 тамирчин оролцож, алт 76, мөнгө 78, хүрэл 108 нийт 262 медаль хүртсэн. | 100% |
| 114 | Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн, хугацаанд нь тайлагнана. | - | Хяналтад авсан тогтоол шийдвэрийн заалтын тоо, үр дүн, тайлан | 15 тогтоол шийдвэрийн 30 заалтын биелэлт 94.2%-тай хэрэгжсэн. | Улирал тутам тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, хугацаанд нь тайлагнана. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, батлуулан, биелэлтийн мэдээг Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 04/1942 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2022 оны жилийн эцсийн байдлаар тайлагнах 46 тогтоол шийдвэрийн холбогдох 85 заалтыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албадаас авч нэгтгэн хяналт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээ үнэлгээ хийлгэж тайлагнасан. Жилийн эцсийн байдлаар 92.6 хувьтай хэрэгжсэн. | |
| 115 | Нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнах, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулна. | - | Шуурхай зөвлөгөөний тоо, үүрэг даалгаврын биелэлтийн хувь | Үүрэг даалгавар 89%-тай хэрэгжсэн. | Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтад танилцуулж, хугацаанд нь тайлагнасан байна. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 24 удаа зохион байгуулагдан, нийт 220 үүрэг даалгавар өгөгдөж, 96.7%-тай хэрэгжсэн. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 40 удаа зохион байгуулан, нийт 189 үүрэг даалгавар өгөгдөж, 92.8%-тай хэрэгжсэн. | 100% |
| 116 | Дүүрэгт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгнө. | - | Хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо, үр дүн, тайлан | 5 төрлийн бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. | Бодлогын баримт бичгүүдэд хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүрэгт хэрэгжих 2 бүлэг, 2 зорилго, 4 зорилт, 5 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 92 хувьтай хэрэгжиж, хяналт-шинжилгээ, үнэлгээний 2 шалгуур үзүүлэлт 100 хувьтай, "Үр дүнтэй" гэж үнэлэгдсэн.<br><br>Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй нийт 19 тогтоол, шийдвэрийн 58 заалтын 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 71,8 хувь, хэрэгжих шатанд байсан бол жилийн эцэст 46 тогтоол, шийдвэрийн 85 заалт 93,3% "бүрэн хэрэгжсэн" гэж үнэлэгдсэн.<br><br>1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 1 бүлэг, 3 зорилт, 3 арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний шалгуур үзүүлэлт гуравдугаар улирлын байдлаар 57хувь, жилийн эцсийн хэрэгжилт нэгтгэгдэж байна.<br><br>2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний 4 бүлэг, 8 зорилт, 16 зорилго, 39 арга хэмжээний шалгуур үзүүлэлт гуравдугаар улирлын байдлаар 91 % Дээрх бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд журмын дагуу жилийн эцсийн байдлаар мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн холбогдох байгууллага албан тушаалтанд хуулийн хугацаанд танилцуулж. тайлагнана. 98%, "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнасан.<br><br>3. Хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт эхний хагас жилд 55.0%, "эрчимжүүлэх шаардлагатай" гэж үнэлэгдсэн бол жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ 91% "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр дүүргийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. | |
| 117 | Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг тавих замаар үүрэг хариуцлагыг дээшлүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | - | Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо, үр дүн | Хяналт-шинжилгээ үнэлгээг 1 удаа зохион байгуулж, үр дүнг тайлагнасан. | 1-ээс доошгүй удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ. | Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 4 бүлэг 32 заалт бүхий зөвлөмжийг харьяа 32 байгууллагад дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 06/344 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/555 дугаар захирамжаар дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээг хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуваарийг баталсан. Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу томилогдсон 3 ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 28-наас 12 дугаар сарын 06-ны хооронд 53 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дуусган тайлан нэгтгэгдэж байна. | 100% |
| 118 | Хороодын хэсгийн ахлагч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна. | 5.0 | Зохион байгуулсан эсэх, үр дүн | Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, 210 хэсгийн ахлагчийг хамруулсан. | Арга хэмжээг зохион байгуулж, холбогдох албан тушаалтад тайлагнасан байна. | Хороодын хэсгийн ахлагч нарын зөвлөлдөх уулзалтыг удирдлагын шийдвэрээр 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулна. | - |
| 119 | Хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хөгжлийн нийгмийн ажилтан нарын дунд ажил мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулна. | 12.0 | Хамрагдсан хороодын тоо, албан хаагчдын тоо | Ур чадварын тэмцээн зохион байгуулагдаагүй. | Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна. | Хороодын албан хаагчдын ур чадварын тэмцээнийг зохион байгуулах арга хэмжээний удирдамжийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмцээнд 24 хорооны 70 албан хаагчид оролцон, мэдлэг, ур чадвараараа өрсөлдсөн. | |
| 120 | Иргэдийн эрэлт, хүсэлт, өргөдөл, гомдлыг ERP "Өргөдөл гомдлын нэгдсэн систем" болон бусад арга хэрэгслээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хариуг иргэнд шуурхай өгч ажиллана. | - | Дүүргийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн индекс, шийдвэрлэлтийн дундаж хоногоор | 2992 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 08 хоног, 01 цаг, 14 минутад шийдвэрлэсэн. | Нийслэлийн түвшингээс доош хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтот түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 5130 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж байгаа 131, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 57, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 4942 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 07 хоног 11 цаг 43 минут<br>Засаг даргын Тамгын газарт нийт 805 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж байгаа 23, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 782 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 06 хоног 08 цаг 14 минут<br>Индекс 0,849/А/ | 100% |
| 121 | Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн иргэдээс гарсан санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана. | - | Уулзалтад хамрагдсан иргэдийн тоо | Нийт 96 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, хариу өгсөн. | Тухай бүр иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулж, санал хүсэлтийг шийдвэрлэж ажиллана. | Нийслэлийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1212 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам", дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан "Дүүргийн Засаг даргын харьяа байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам"-уудад заасны дагуу Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 1360 иргэдтэй 8 удаагийн уулзалтыг зохион байгуулж, иргэдийн санал хүсэлт, тулгамдаж асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажилласан. | |
| 122 | Иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ажлыг зохион байгуулна. | - | Буцалтгүй тусламжид хамрагдсан иргэдийн тоо | 92 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. | Журмын дагуу иргэдэд буцалтгүй тусламж олгосон байна. | Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журам"-д заасны дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн 159 иргэнд 381.000.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна. | 100% |
| 123 | Цахим баримт бичгийг хүлээн авах, шуурхай хянан шийдвэрлэх, цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлж ажиллана. | - | Баримт бичгийн шийдвэрлэлтийн байдал | 2021 онд нийт 2384 бичиг боловсруулагдсан. | Баримт бичгийн шийдвэрлэлт зөрчилгүй, шуурхай шийдвэрлэсэн байна. | Хан-Уул дүүргийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 38928 албан бичиг ирснээс судлагдаж байгаа 768, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 678, хуулийн хугацаандаа шийдвэрлэсэн 37482 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 06 хоног 04 цаг 06 минут, Индекс 0,733/В/ байна.<br>Засаг даргын Тамгын газарт нийт 4523 албан бичиг ирснээс судлагдаж байгаа 99, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 103, хуулийн хугацаандаа шийдвэрлэсэн 4321 байна.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 05 хоног 09 цаг , Индекс 0,737/В/ байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагаас боловсруулсан 2084 албан бичгийг бүртгэж цаасан болон цахим хэлбэрээр илгээн MNS5140:2021 стандартыг мөрдөн ажилласан. | |
| 124 | Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн ажиллана. | - | Стандартыг мөрдүүлж ажилласан эсэх | MNS5140:2011 стандартыг мөрдөн ажилласан. | Баримт бичгүүд стандартын дагуу боловсруулагдсан байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны 6800 албан бичгийн боловсруулалтад Монгол улсын MNS 5140:2021 стандартыг мөрдүүлж ажилласан. | 100% |
| 125 | Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар батлуулах. | - | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалын батлуулсан эсэх | Засаг даргын Тамгын газрын 2021 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 223 хэрэгтэйгээр шинэчлэн боловсруулж, байгууллагын БНШК-ын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулна. | Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 196 хэрэгтэйгээр шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулан хэлтэс, албадад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 126 | Төрийн архивт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нөхөн бүрдүүлэлт хийх хөмрөг үүсгэгч байгууллагын нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, данс бүртгэлийг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулах. | - | Төрийн архивт хөмрөг үүсгэсэн байгууллага, баримтын тоо | БНШАЗК -ын хурлыг 1 удаа хуралдуулсан. | Дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлыг зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, ажиллана. | Дүүргийн архивын 2022 оны төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлтийн 14 байгууллага, төлөвлөгөөт бус 2 байгууллага нийт 16 байгууллагын архивын баримт, данс бүртгэлийг хянаж, 96 удаа мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн. БНШАЗК-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар 5 байгууллагын данс бүртгэлийг хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэж, 9 байгууллагын баримтыг архивын байрны багтаамжаас шалтгаалан 2023 онд хүлээн авахаар хойшлуулж шийдвэрлэсэн. | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 127 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт болон тусгай төрлийн баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нягтлан шалгаж хүлээн авах. | - | Хүлээн авсан баримтын тоо | Байгууллагын архивт 580 баримтыг хүлээн авсан. | Баримт бичгийг стандартын дагуу архивлаж нөхөн бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийг Засаг даргын Тамгын газрын даргаар 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлуулан, хуваарийн дагуу 715 хадгаламжийн нэгжийг хүлээн авч баяжилт хийсэн. | 100% |
| 128 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн төсөл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Төсөл арга хэмжээний арга тоо | Хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн цахим аян, 6 удаагийн сургалтад 18826 иргэнийг тус тус хамруулсан. | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 400 иргэнийг хамруулна. | Хан-Уул дүүргийн Жендэрийн дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Нандин үерхэл", "Харилцан хүндэтгэе", "Нандин бүхнээ хамгаалъя" аяныг зохион байгуулж, давхардсан тоогоор 12000 гаруй иргэнд мэдээллийг хүргэж ажилласан.<br>"Гэр бүл дэх тэгш байдал", "Гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, оролцоо" зэрэг сургалт, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг www.khan-uul.mn, www.khanuul.child.gov.mn сайт, "Хан-Уул Эко дүүрэг", "Хан-Уул хүүхэд" болон хороодын албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан.<br>Хан-Уул дүүргийн Жендэрийн салбар хорооноос төрийн захиргааны болон үйлчилгээний 75 байгууллагад "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11.4, 11.5, 11.6, 11.7 дахь хэсгийн зохицуулалтыг тусган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг хүргүүлсэн бөгөөд 63 байгууллага дотоод журамд тусган, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 129 | Аж, ахуйн нэгж байгууллага болон иргэдийн шагналын асуудлыг хэлэлцүүлэн дэмжүүлж, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, хамруулсан иргэдийн тоо | 375 иргэнд шагнал гардуулсан. | Шагналын журмын хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан 350 иргэнийг төрийн дээд одон медалиар, 1 аж ахуйн, нэгж байгууллагыг "Алтан гадас" одонгоор шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хүлээн авч хянан, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 04, 11, 15 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн Хүндэт тэмдгээр 143 иргэн, ажилтан албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Яам салбарын шагналаар шагнуулах иргэн, аж ахуй, нэгж байгууллагын 150 иргэний материалыг дэмжин уламжилсан. Алдарт эхийн 1, 2 дугаар одон авах 803 эхчүүдийн 31 боть архивын баримтыг НЗДТГ-т хүргүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр зарлигаар "Алдарт эх"- I, II дугаар зэргийн одонгоор 803 эхчүүд шагнагдаж одонгоо гардаж авсан. | 100% |
| 130 | Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулна. | - | Зохион байгуулсан хурлын тоо, шийдвэрлэлтийн хувь | 45 удаагийн хурал зохион байгуулж 211 асуудлыг хэлэлцсэн. | Шийдвэрийн биелэлтийг тайлагнасан байна. | Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу 38 удаа зохион байгуулж, 270 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Тус хурлаас 173 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийн явц 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 88 хувьтай байна. | |
| 131 | Гадаадын зочид төлөөлөгчидтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааны хүрээнд санал хүргүүлж, хоёр талын хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулна. | - | Санал хүргүүлж, уулзалт зохион байгуулсан эсэх | - | 2-оос доошгүй санал хүргүүлнэ. | Турк Улсын Болгар хотын Засаг дарга болон төлөөлөгчдийг 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд хүлээн авч, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр албан уулзалтыг зохион байгуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хоттой хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр шинээр холбоо тогтоох албан хүсэлтийг уламжлан цахим уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Япон, Солонгос, Хятад, Турк, Канад, ӨМӨЗО зэрэг нийт 6 улс руу гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх албан бичиг хүргүүлэн, Солонгос улсын Хаман сумын Засаг даргыг улиран сонгогдсонд баярын мэндчилгээг тус хүргүүлэн ажилласан. Мөн Бүгд Найрамдах Турк улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хэрхэн дэмжин ажилладаг талаар туршлага судлахаас гадна Турк улсын түүх соёл, амьдралын хэв маягтай танилцан туршлага солилцохоор 4 удаагийн томилолтоор 27 ажилтан, албан хаагчдын ажиллуулсан. БНСУ-ын Нам дүүргийн Халимны фестивальд Тамгын газрын 6 албан хаагчийг тус тус хамруулсан. | 100% |
| 132 | Гадаад, дотоодын байгууллагуудтай гэрээ, санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ санамж бичиг байгуулсан эсэх, гүйцэтгэлийн тоо | . | 2-оос доошгүй байгууллагатай гэрээ, санамж бичиг байгуулна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар, "Хаан банк"-тай хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан дүүргийн 12 дугаар хороонд 3*3 сагсан бөмбөгийн шинэ талбайг байгууллаа. Монголын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөлбөмбөгийн холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан 2 дугаар хорооны 52 дугаар сургуулийн гадна талбайд Олон Улсын стандарт бүхий хөлбөмбөгийн талбайг шинээр тохижуулллаа. | |
| 133 | Дүүргийн иргэдийг үнэн зөв ил тод шуурхай мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна. | - | Иргэдэд хүргэсэн мэдээ, хандалтын тоо | 2985 мэдээ мэдээллийг дүүргийн цахим хуудаснуудад байршуулсан. | Иргэдэд мэдээ, мэдээлэл шуурхай хүрсэн байна. | Төрийн үйлчилгээг иргэдэд үнэн зөв ил тод , түргэн шуурхай хүргэх зорилгоор Хан-Уул Эко дүүрэг цахим хуудаст нийт 4501 мэдээ, мэдээлэл, видео шторк, постер бэлтгэж 21.987 иргэнд хүргэсэн. Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим /www.khanuul.mn/ вэб сайтад байгууллагын ил тод байдал, хууль тогтоомж, нийслэл, дүүргийн шийдвэр зэрэг нийт 2852 мэдээллийг байршуулсан бөгөөд "Дүүргийн англи танилцуулга"-тай вэб сайтыг шинээр нээн ажиллуулж байна.<br>Дүүргийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг иргэдэд нээлттэй мэдээллэх үүднээс "Эко дүүргийн нээлттэй бямба гараг" арга хэмжээг 9,10 дугаар сарын бямба гараг бүр зохион байгуулж хамтран ажилладаг 36 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 19 лайв, 25 сурвалжлага, 11 ярилцлага, 24 нийтлэл, 91 мэдээ бэлтгэн иргэдэд мэдээллийг шуурхай хүргэсэн. | 100% |
| 134 | Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянаж, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцох. | - | Захиргааны акт хуульд нийцсэн хэрэгжилтийн хувь | Биелэлт 95,7% | Захиргааны акт хуульд нийцэн 95%-иас дээш хэрэгжсэн байна. | Дүүргийн Засаг даргын 643 захирамж, ЗДТГ-ын даргын 291 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Засаг даргын үйл ажиллагаа зохион байгуулсан 343 захирамжийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелэлт 95.7% буюу хангалттай хэрэгжиж байна. | |
| 135 | Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах гэрээний үндэслэлийг хянан бүртгэлжүүлэх. | - | Бүртгэлжүүлсэн гэрээний тоо | 471 гэрээг хянаж бүртгэлжүүлсэн | Гэрээ хуульд нийцсэн 100% бүртгэлжүүлсэн байна. | Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 607 гэрээний эрх зүйн үндэслэлийн хянан бүртгэлжүүлсэн. | 100% |
| 136 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, маргаан, нэхэмжлэлтэй холбогдуулан итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын байгууллагатай харилцана. | - | Шүүхэд төлөөлсөн үйл ажиллагааны хувь | 24 хэрэг маргаанд оролцсон. | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 100% төлөөлөн оролцсон байх | Захиргааны хэргийн шүүхэд 12, иргэний хэргийн шүүхэд 1, цагдаагийн байгууллагад 1 нийт 14 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцсон.<br>Үүнээс анхан шатны шүүхийн 24, давж заалдах шатны шүүхийн 15, дээд шатны шүүхийн 2 нийт 31 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож:<br>- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж гэрээ байгуулахыг даалгасан 3,<br>- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 8 | 100% |
| 137 | Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалт, сурталчилгаар иргэд, албан хаагчдад зохион байгуулна. | 3.0 | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэд, албан хаагчдын тоо | 14 Сургалт, 1622 иргэд, албан хаагчийг хамруулсан | 8 сургалт зохион байгуулж, 400 иргэн, албан хаагч хамруулах | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан "Хууль, эрх зүйн сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хуульчдын холбоо, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Удирдлагын академитэй хамтран 10 сургалтыг зохион байгуулж 710 албан хаагч, иргэдийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 138 | Эрх зүйн ажлын тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ. /ХЗДХЯ, ҮАБЗ, НЗДТГ/ | - | Хэрэгжилтийн хувь | 2 удаа тайлан хүргүүлсэн. | Тайланг нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2022 онд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг нэгтгэж ЗДТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/916 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Хан-Уул дүүрэгт эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэж ЗДТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 11/1055 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу дүүрэгт хэрэгжүүлсэн хагас жилийн ажлын тайланг нэгтгэж ЗДТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 11/1076 дугаартай албан бичгээр Монол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн. | 100% |
| **ЗУРГАА. БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 6** Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 139 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Цэргийн бүртгэлийн хамрагдалтын хувь | 92,4 хувьтай хэрэгжсэн. | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдана. | Хан-Уул дүүргийн 2022 оны цэргийн бүртгэлийг "Цэргийн албаны тухай хууль"-ийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/331 дүгээр журам, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/980, дүүргийн Засаг даргын 2021 оны А/657 дугаар захирамжийг тус тус хэрэгжүүлэн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 21-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтайгаар 93,8% зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 140 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2022 оны ээлжит цэрэг халалт, татлагын үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Цэрэг татлагын арга хэмжээг зохион байгуулсан эсэх, тоон даалгаврыг биелүүлсэн эсэх. | 100 хувьтай хэрэгжсэн. | Зэвсэгт хүчин , Хилийн цэрэг, Дотоодын цэргийн нөхөн хангах тоон даалгавар биелэгдэнэ. | Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/234 дүгээр захирамжийн дагуу Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн тоон Хилийн ба дотоодын цэргийн нөхөн хангах тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1127 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/492 дугаар захирамжийг үндэслэн хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн 10 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн Зэвсэгт хүчин, Хилийн ба дотоодын цэргийн тоон даалгаврыг 78 хувь биелүүлсэн.<br>Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн 18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс 135 өргөдлийг ирүүлж, Цэрэг татлагын товчооны эрүүл мэндийн үзлэгээр оруулан Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийг үндэслэн ээлжит цэрэг татлагаас түр чөлөөлж шийдвэрлэсэн. | 100% |
| 141 | Дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын 18-50 насны цэргийн үүрэгтний Батлан | - | Үзлэг явуулсан аж ахуй нэгж | 100 хувьтай 6 ААНБ-ыг шалгасан. | Батлан хамгаалах салбарыг сурталчилсан байна. | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг жилийн эцсийн байдлаар дүүргийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үзлэг шалгалт явуулна. | | байгууллагын тоо | | | Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 5 байгууллагын 18-50 насны 465 цэргийн үүрэгтний нэрсийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 75 хувийг хамруулснаас 37.6 хувь нь зөрчилтэй байсан.<br>1973-1996 онд төрсөн цэргийн алба хаагаагүй 67 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 24 иргэнээр 9,217,825 төгрөгийг төлүүлж нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.<br>Байгууллага, аж ахуйн нэгжид цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулснаар иргэний цэргийн зөрчил буурч байна. | |
| 142 | Дайчилгааны тухай хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулна. | - | Сургалтуудыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтний тоо | 2 удаа сургалт зохион байгуулсан. | Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, цэргийн дүйцүүлэх алба хаагчдад хууль эрх зүйн болон цэргийн хэргийн мэдлэг олгож, үүрэг гүйцэтгэх дадлага эзэмшүүлсэн байна. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны н/01 дүгээр захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын н/01 дүгээр захирамжаар цэргийн бэлтгэл албаны сургалтад хамрагдах иргэдийн судалгааг гаргаж, мэдэгдэх хуудас хүргүүлэн сургалтын гэрээг байгуулан Зэвсэгт хүчний 065, 310 дугаар ангиудад 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр, Зэвсэгт хүчний 303 дугаар ангид 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг нарядын дагуу тус тус бүрэн хүлээлгэн өгсөн.<br>Сургалтад хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтнийг эзэмшсэн мэргэжил, даалгаврын дагуу анги командад оногдуулан бүртгэсэн. | 100% |
| 143 | “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх” сэдэвт | - | Болзолт уралдааныг зохион байгуулан | 92 хувьтай хэрэгжсэн. | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр | 92% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болзолт уралдааныг Өрхийн эрүүл мэндийн төвүүд, нарийн мэргэжлийн их эмч нарын дунд зохион байгуулах, үр дүнг тооцох. | | дүгнэж, үр дүнг тооцсон эсэх | | тодорхой хувиар дээшилсэн байна. | тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" болзолт уралдааны үр дүнг тооцсон. | |
| 144 | Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад оролцох, дотооддоо батлан хамгаалах хууль, тогтоомжоор сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад оролцох, дотооддоо батлан хамгаалах хууль, тогтоомжоор сургалт зохион байгуулагдана | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/188 дугаар тушаалаар 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Налайх дүүрэгт зохион байгуулагдсан нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад бие бүрэлдэхүүн бүрэн оролцсон. Сургалтын бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон багц хуулиар офицер, ахлагч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 15, 11 дүгээр сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. | 100% |
| 145 | Дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулна. | - | Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээн зохион байгуулсан эсэх, хамрагдсан сурагчдын тоо | - | Ерөнхий боловсролын 18 сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан байна. | Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 2022 оны 04 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд Ерөнхий боловсролын сургуулийн 17 багийн 221 сурагчид оролцож, тэмцээний удирдамж, зааврын дагуу 17 үзүүлэлтээр зохион | 94% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, баг онооны системээр дүгнэж, тэргүүн байрыг 7 дугаар сургуулийн **“ХУРД”** баг, **4** дэд байрыг 60 дугаар сургуулийн **“Оргил”** баг, гутгаар байрыг 10 дугаар сургуулийн **“Ялалт”** баг тус тус эзэлсэн.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээн 2022 оны 08 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр анги, Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдаж, тус дүүргээс 7 дугаар сургуулийн “Хангарьд” багийн тамирчдыг бэлтгэн оролцуулж, 7 дугаар байрт шалгарсан. | |
| 146 | Дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид, их дээд сургуулийн оюутнуудад төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэх, батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчлах. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 86 хувьтай хэрэгжсэн. | ААНБ-ын ажилтан албан хаагчид, их дээд сургуулийн оюутнуудын хууль эрх зүйн мэдлэг дээшилж, төрийн батлан хамгаалах үйлчилгээ авна | Батлан хамгаалах бодлогын үндэс, салбар багц хуулийг сурталчлах ажлын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Хөдөө аж ахуйн их сургуулийн “Хатантуул” театрт 340 гаруй оюутанд батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчилан танилцуулах уулзалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын хуулийн багтай хамтран зохион байгуулсан. | 100% |
| 147 | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран “Монгол цэргийн бахархал” өдөрлөгийн арга хэмжээг дүүргийн иргэдтэй зохион байгуулна. | - | “Монгол цэргийн бахархал” өдөрлөг зохион байгуулсан эсэх, оролцсон иргэдийн тоо | - | Иргэд, хүүхэд залуучуудын батлан хамгаалах салбарын хууль эрх зүйн мэдлэг дээшилж, эх оронч үзэл төлөвшиж, иргэн-цэргийн харилцаа дээшилнэ | Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан төлөвлөгөөт 15 ажлаас 13 ажил биелэгдэж хэрэгжилт 86,6 хувьтай биелсэн.<br>Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний анги төрийн, цэргийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллага-2, ерөнхий боловсролын сургууль-21 нийт 26 байгууллагатай хамтран ажиллаж, ерөнхий боловсролын сургуулийн 8 багш, 224 сурагч, албан тушаалтан, иргэн 240, нийт 470 гаруй иргэдийг оролцуулж үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| 148 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2022 оны "Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | - | "Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан оюутны тоо | - | Их, дээд сургуулийн оюутан болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн хугацаат цэргийн алба хаах боломж олгогдоно. | Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны А/131 дүгээр захирамжийн дагуу "Оюутан-Цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2022 оны 03 дугаар сарын 01-11-ний өдрийг дуустал үндэсний портал сайт "E-Mongolia"-аар хүлээн авсан. Дүүргийн хэмжээнд 2022 онд 9 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 52 оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдсан. Эрүүл мэндийн үзлэг, бие бялдаржилтын шалгалтад тэнцсэн 42 оюутныг Үндэсний батлан хамгаалахын их сургуульд хүлээлгэн өгсөн. | 100% |
| 149 | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна. | - | Томилгоот бүрэлдэхүүний сургалт зохион байгуулагдсан эсэх, оролцсон албан тушаалтны тоо | 100 хувьтай хэрэгжсэн | Томилгоот албан тушаалтнуудын үүрэг гүйцэтгэх мэдлэг дадлага дээшилсэн байна. | Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хээрийн байрлалд зохион байгуулсан. Тус сургалтад орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сумангийн дарга бэлтгэл хурандаа М.Батсайхан, Хангалт зохион байгуулах сумангийн дарга бэлтгэл хурандаа П.Буянхүү, Сэтгэл зүйн хангалтын салааны захирагч бэлтгэл дэд хурандаа Ц.Зоригтбаатар, Тээвэр нүүлгэн шилжүүлэх сумангийн дарга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэл ахмад Д.Энхбат сумангийн удирдлагын бүрэлдэхүүнд хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч, хурандаа Б.Эрдэнэбил тус сургалтын явцтай танилцсан. | |
| 150 | Хорооны Засаг дарга нарын Цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулах. | - | Сургалт зохион байгуулагдсан эсэх, ирцийн хувь | - | Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдсан байна. | Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ, дүүргийн Засаг даргын 2022 оны А/456 дугаар захирамжийн дагуу хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2022 оны 9 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Цэргийн бэлтгэл сургалтад дүүргийн 24 хорооны Засаг дарга нар 91.7 хувийн ирцтэй хамрагдсан. | 91,7% |
| 151 | Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх. | - | Мөнгөн төлбөрөөр орлуулан хаах иргэдийн хувь, төлсөн мөнгөн дүн | 100 хувьтай хэрэгжсэн. | Батлагдсан нэрсийн жагсаалтын дагуу мөнгөн төлбөрийг барагдуулж, бүртгэл тооцоо хөтлөгдсөн байна. | Цэргийн албаны тухай хуулийн 29.3-д заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1994-1996 онд төрсөн 235 иргэнээр 210.3 сая төгрөгийг төлүүлж Нийслэлийн төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлэн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг гаргаж Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт 11 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. | 100% |
| 152 | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ. | - | Шилжилт хөдөлгөөний тоо, хувь | 100 хувьтай хэрэгжсэн. | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөн бүртгэгдэнэ. | Хан-Уул дүүргээс 2022 оны жилийн эцсийн байдлаар шилжилт хөдөлгөөний журмын дагуу шилжин явсан-156, шилжин ирсэн-357 цэргийн үүрэгтнийг бүртгэж, цэргийн бүртгэлийн мэдээллийн санд оруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 153 | Монгол Улсын Дайчилгааны хуулийн дагуу Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хүн, техникийн дайчилгааны тодотгол явуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | 85 хувьтай хэрэгжсэн. | Зэвсэгт хүчний анги, байгууллагатай явуулах дайчилгааны тодотгол хийгдэнэ | Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны оч/мн 600/02 дугаар удирдамжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны н/02 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны н/01 дүгээр захирамжаар цэргийн дайчилгааны тодотголыг Улаанбаатар цэргийн хүрээний болон орон нутгийн ангитай 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд, дайчилгааны 2 дахь ээлжийн тодотголыг 2022 оны 11 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний ангиудаас холбогдох албан тушаалтнууд ирж тус тус зохион байгуулсан.<br>Зэвсэгт хүчний Жанжин штаб, Нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний командад оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдийг 2022 оны цэргийн бүртгэлийн баримт бичигтэй тулгалт хийн шалгахад шилжсэн, гадаадад, хаягандаа байхгүй, нас барсан гэх мэт шалтгаанаар өөрчлөлт орсон бэлтгэл офицер , цэргийн үүрэгтэнг тухай бүр шинээр оногдуулан бүртгэж ажилласан. | 100% |
| 154 | Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлж, сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 100 хувь хэрэгжсэн. | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журмын дагуу иргэдийг сонгон дүйцүүлэх албанд элсүүлж, үүрэг гүйцэтгүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 220 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/771, дүүргийн Засаг даргын 2022 оны А/324 дүгээр захирамжаар 2022 онд цэргийн дүйцүүлэх албанд элсэхээр хүсэлт гаргасан 6 иргэнийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалж, цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэн алба хаах гэрээг байгуулсан. Цэргийн дүйцүүлэх албанд элссэн алба хаагчдад 2022 оны 06 дугаар 17-30-ны өдрүүдэд цэргийн анхан шатны сургалтыг Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх үеийн мэдлэг дадлагыг олгосон. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА ........................................ Ж.АЛДАРЖАВХЛАН

ТАМГА ........2022-12-09........

(огноо)

ТАЙЛАГНАСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ........................................ С.ЭНХБАЯР

ТАМГА ........2022-12-09........

(огноо)